



Шинжээчийн багийн үнэлгээний тайлан

Байгууллагын нэр: ХААИС-ийн Агроэкологийн сургууль

Хөтөлбөрийн нэр: Аялал жуулчлал

Индекс: 101501 бакалавр

Шинжээчийн баг:

Ахлагч: Д. Гансүх

Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн төвийн удирдах зөвлөлийн дарга, доктор

Гишүүд: Ч. Мөнхжаргал

Соёл Урлагийн Их Сургуулийн Соёлын сургуулийн Соёл судлалын тэнхимийн ахлах багш, дэд профессор, доктор

Ц.Пүрэвтуяа

Санхүү эдийн засгийн их сургуулийн дэд профессор, доктор

Он сар өдөр: 2023. 03.06

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нартай хийх уулзалт

II. Оюутан, суралцагчидтай хийх уулзалт

III. Ажил олгогчидтой хийх уулзалт

IV. Төгсөгчидтэй хийх уулзалт

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

АЖБЧБС	Аялал Жуулчлалын Боловсролын Чанарын Баталгаажуулалтын Систем (TedQual – Tourism Education Quality)
АЭС	Агроэкологийн Сургууль
БМИҮЗ	Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл
БОАЖЯ	Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам
БШУ	Боловсрол, Шинжлэх Ухаан
БШУЯ	Боловсрол, Шинжлэх Ухааны Яам
ЕБС	Ерөнхий Боловсролын Сургууль
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
СБЗА	Сургалтын Бодлого Зохицуулалтын Алба
ТББ	Төрийн Бус Байгууллага
ӨҮТ	Өөрийн Үнэлгээний Тайлан
ҮИС	Үндэсний Их Сургууль
ХААИС	Хөдөө Аж Ахуйн Их сургууль
ЧУА	Чанарын Удирдлагын Алба
ЧУТ	Чанарын Удирдлагын Тогтолцоо
ЭЕШ	Элсэлтийн Ерөнхий Шалгалт
ЭШ	Эрдэм Шинжилгээ
CDIO	Conceive Design Implement Operate
ISO	International Standard Organization
SWOT	Strength Weakness Opportunity

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	ХААИС-ийн Агроэкологийн сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Аялал жуулчлал	
Индекс	101501 бакалаврын хөтөлбөр	
Шинжээчид	1. Ахлагч: Д.Гансүх 2. Гишүүн: Ч.Мөнхжаргал 3. Гишүүн: Ц.Пүрэвтуяа	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Ж.Мөнхбилэг - БМИҮЗ-ийн магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу
	2023.01.31	Шинжээчийн багийг томилох
	2023.01.31	Шинжээчидтэй гэрээ байгуулах
	2023.02.02	Шинжээчдэд өөрийн үнэлгээний тайланг хавсралтын хамт хүлээлгэн өгнө.
	2023.02.10	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2023.02.15-16	Сургууль дээр очиж шинжээчид ажиллана.
	2023.02.27	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2023.02.27	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна.
	2023.02.28	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2023.02.28	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.
	Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.	
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Манай улсын хувьд аялал жуулчлалын салбар нь эдийн засагт оруулах хувь нэмрээрээ уул уурхай болон хөдөө аж ахуйн салбарын араас гуравт ордог чухал том салбар юм. “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогод “Үндэсний онцлог бүхий, хүрээлэн буй орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд оршино” зэргээр заасан бөгөөд 2023-2025 оныг Монгол зочлох жил болгон Засгийн Газраас зарласан нь энэ мэргэжлээр төгсөгчдийн ажлын байрыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой болж байна.

Аялал жуулчлал мэргэжлийн хөтөлбөрийг хөдөө аж ахуй, байгаль экологи, газар зүйн суурь онцлогтойгоор хэрэгжүүлэхдээ ХААИС-ийн эрхэм зорилгын “хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийн чиглэлээр шинжлэх ухаан сургалт, үйлдвэрлэлийн хосолсон” мэдлэг ур чадвар олгох замаар Монголын нүүдлийн мал аж ахуй, байгаль, хүрээлэн буй орчинд түшиглэсэн аялал жуулчлалын сургалтыг явуулдаг. Иймээс ХААИС-ийн “Аялал жуулчлал” мэргэжлийн хөтөлбөр нь байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах, тогтвортой хөгжлийн зарчмууд болон хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагааг аялал жуулчлалын салбартай хэрхэн холбох талаар судалдагараа бусад 10 гаруй их, дээд сургууль дээр бэлтгэдэг аялал жуулчлалын хөтөлбөрүүдээс ялгагдах онцлогтой юм.

“Аялал жуулчлал”-ын мэргэжлийн анги 1999 онд тухайн үеийн Суурь боловсролын факультетэд шинээр нээгдэж, 2003 онд анхны төгсөлт хийснээр энэ мэргэжлийн хөтөлбөр хэрэгжиж аялал жуулчлал, байгаль орчин, зочлох үйлчилгээний салбарт 717 мэргэжилтэн бэлтгэн гаргажээ. Энэхүү сургалтын хөтөлбөр нь 2011 оны 06 сарын 23-ны өдөр дотоодын магадлан итгэмжлэл хийлгүүлэн БМИУЗ-ийн 75 тоот гэрчилгээг гардан авсан нь Монгол улсын хэмжээнд байгалийн аялал жуулчлал хөтөлбөрийн анхны магадлан итгэмжлэл болсон байдаг.

Одоо магадлан итгэмжлүүлэхээр хүсэлт гаргасан “Аялал жуулчлал” сургалтын төлөвлөгөөг НҮБ-ын Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллагаас хэрэгжүүлж буй Аялал жуулчлалын боловсролын чанарын баталгаажуулалтын систем – АЖБЧБС (TedQual – Tourism Education Quality), түүний зорилго, зорилтод нийцэж буй, тус газраас баталгаажсан гадаадын 4 их дээд сургуулиудын хөтөлбөр болон Монгол улсад аялал жуулчлалын чиглэлээр сургалт явуулж байгаа 5 их, дээд сургуулиудын хөтөлбөртэй харьцуулалт хийсэн байна.

Хөтөлбөрийн зорилгыг *“байгаль, нийгэм, эдийн засгийн ухааны суурь мэдлэгийг аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарын онол, практиктай уялдуулж хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцсэн, орчин үеийн чиг хандлага, техник технологийн дэвшлийг хослуулан ашиглах бүтээлч сэтгэхүйтэй зөөлөн ур чадвар бүхий аялал жуулчлалын мэргэжилтэн бэлтгэх”* явдал хэмээн тодорхойлжээ.

Сургалтын төлөвлөгөөний нийт 124 кр цагийн багтаамжинд 37 кр цагийн 13 ерөнхий суурь хичээл, 27 кр цагийн 9 мэргэжлийн суурь хичээл, 45 кр цагийн 11 мэргэшүүлэх хичээл, 6 кр цагийн 2 сургалтын дадлага, 6 кр цагийн 1 үйлдвэрлэлийн дадлага, 3 кр цагийн 1 төгсөлтийн ажилтайгаар төлөвлөсөн байна.

“Аялал жуулчлал” хөтөлбөрт хичээл зааж байгаа 21 багшийн 12 нь докторын /Ph.D/ зэрэгтэй байна.

Аялал жуулчлал хөтөлбөрөөр 2021-2022 оны хичээлийн жилд нийт 57 оюутан суралцаж байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Аялал жуулчлал бакалаврын сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа бакалаврын сургалтын хөтөлбөрт тавигддаг нийтлэг эрх зүйн баримт бичгүүдийг үндэслэсэн ба тухайлбал Дээд боловсролын тухай хууль, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024), Дээд боловсролын бакалаврын мэргэжлийн хөтөлбөрт тавигдах “Нийтлэг шаардлага батлах тухай” БШУ-ны сайдын 2014 оны 4-р сарын 28- ны өдрийн А/174 тоот тушаал, 2021 он хүртэлх дээд боловсролын хөгжлийн бодлогын зорилт, үр дүнд суурилсан боловсролыг хөгжүүлэх бодлого (2018), “Мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс шинэчлэн батлах тухай” БШУ-ы сайдын 2022 оны 5-р сарын 9-ний өдрийн А/160 тоот тушаал зэрэг эрхзүйн баримтууд төдийгүй ХААИС-ийн захирлын 2022 оны А/194 дугаар тушаалаар батлагдсан “ХААИС-ийн сургалтын журам” зэрэг баримт бичгүүдийг үндэслэл болгосон.
- ХААИС-д аялал жуулчлал хөтөлбөрийн байгалийн аялал жуулчлал мэргэжилтэн бэлтгэж ирэхдээ сургалтын хөтөлбөрийн агуулгад цаг үеийн нөхцөл байдал, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн (1999, 2007, 2011, 2014, 2017) өөрчлөлт хийж сайжруулан ажиллаж ирсэн байна. ХААИС нь аялал жуулчлалын мэргэжилтний эрэлт хэрэгцээг үндсэн 5 үзүүлэлтүүдээр судалж, судалгааны үр дүнг хөтөлбөрийн зорилго, агуулганд тусган ажилладаг.
- ХААИС-ийн аялал жуулчлал мэргэжлээр төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт одоогоор 70.1% байгаа нь ажлын байр нэмэгдэхэд төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх боломжтой гэж үзсэн байна.

Онцлог зүйл:

- “Аялал жуулчлал” мэргэжлийн хөтөлбөрийн хичээлүүдийн агуулгын 62.12% нь дотоодын бусад их, дээд сургуулиудын ижил мэргэжлээр бэлтгэдэг хөтөлбөрүүдтэй нийцэж байна.
- Аялал жуулчлал хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний хичээлүүдийн 32.9 орчим хувь нь сонгон авч харьцуулан судалсан 4 гадаадын их, дээд сургуулиудын адил мэргэжлийн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний хичээлүүдтэй, харин 62.12% нь дотоодын 5 их, дээд сургуулийн сургалтын төлөвлөгөөний хичээлүүдтэй нийцэж байгаа нь ХААИС-ийн аялал жуулчлал мэргэжлийн хөтөлбөрөөр судалдаг хичээлүүд нь гадаад, дотоодын ижил мэргэжлийн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөтэй уялдаж байгаа бөгөөд Монгол улсын болон ХААИС-ийн “Аялал жуулчлал” мэргэжлийн хөтөлбөрийн онцлогийг ч бас хадгалж чадсан байна.
- ХААИС-ийн захирлын 2015 оны 11 сарын 24-ны өдрийн А/377 тоот тушаалаар батлагдсан “ХААИС-ийн хөтөлбөрийн хорооны журам”-ын 7.7. заалтын дагуу 2017 онд батлагдсан сургалтын төлөвлөгөөг 4 жилийн дараа шинэчлэх тухай тушаал гарсан. ХААИС-ийн захирлын 2021 оны 04 сарын 20-ны өдрийн А/50 тоот тушаалын дагуу АЭС-ийн экологийн тэнхимийн аялал жуулчлал хөтөлбөрийг шинэчлэн боловсруулахаар болж

сайжруулалт хийгдээд Экологийн тэнхимийн хамт олны 2021 оны 4-р сарын 25-ны өдрийн хурлаар хөтөлбөрийн зорилго, зорилтыг шинэчлэн хэлэлцүүлж санал авч сайжруулсан.

Анхаарах асуудал:

- “Аялал жуулчлал-101501” хөтөлбөр нь одоог хүртэл хэрэгжүүлж ирсэн Байгалийн аялал жуулчлал хөтөлбөрийн эрэлт хэрэгцээ, шаардлагад тулгуурласан байх бөгөөд зарим хичээлүүдийг, тухайлбал байгалийн аялал жуулчлалын чиглэлийн хичээлүүдийн давхцал, залгамж холбоог судалж, шаардагатай гэж үзвэл өөрчлөлт хийх шаардлагатай байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- “Аялал жуулчлал” хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд одоо хэрэгжиж байгаа Европын холбооны Erasmus+ MONGWBL төслийн туршилтын үр дүнгээр сайжруулалт хийж болох ч цаашид нийт кредит цагийг өөрчлөхгүйгээр харин дадлагын ажлын чанар, сургалтын арга зүйг илүү сайжруулах замаар хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр ажиллах.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн аялал жуулчлал хөтөлбөрийн зорилго, зорилтыг сургалтын төлөвлөгөөг өөрчлөх үед хамгийн сүүлд 2021 онд АЭС-ийн хөтөлбөрийн хорооны 10 дугаар сарын 01-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, улмаар 2022 онд хөтөлбөрт гадаад, дотоод орчны шинжилгээ хийж зорилго, зорилтуудыг сайжруулсан байна. Аялал жуулчлал мэргэжлийн хөтөлбөрийн зорилго нь *“байгаль, нийгэм, эдийн засгийн ухааны суурь мэдлэгийг аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарын онол, практиктай уялдуулж хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцсэн, орчин үеийн чиг хандлага, техник технологийн дэвшлийг хослуулан ашиглах бүтээлч сэтгэхүйтэй зөөлөн ур чадвар бүхий аялал жуулчлалын мэргэжилтэн бэлтгэх”* явдал хэмээн тодорхойлсон. Тус хөтөлбөр нь “Дээд боловсролын тухай” хуулийн “мэргэжлийн өндөр түвшинд ажиллах мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж, өндөр соёлтой иргэн төлөвшүүлэхэд чиглэгдэнэ” гэсэн заалттай нягт уялдаатай бөгөөд цар хүрээ, агуулгын хувьд БШУЯ, БОАЖЯ, ХААИС-ийн эрхэм зорилгод нийцдэг.
- Хөтөлбөрийн цогц чадамжийг 3 багц мэдлэг, 2 багц чадвар, 1 багц хандлага байдлаар тодорхойлсноос гадна хөтөлбөрийн зорилгын хүрээнд үндсэн 8 зорилтыг дэвшүүлсэн байна. Ерөнхий ур чадварын хүрээнд 6 зорилтот үр дүн, аялал жуулчлалын мэргэжлийн ур чадварын хүрээнд 7 зорилтот үр дүн, хөтөлбөрөөр эзэмших хувь хүний хандлагын хүрээнд 6 зорилтот үр дүнг тус тус тусгажээ.

Онцлог зүйл:

- “Аялал жуулчлал” хөтөлбөрийн зорилт нь суралцагчдын эзэмших мэдлэг, ур чадвартай нягт уялдаатай боловсруулагдсан байна.

- Хөтөлбөрийн баримт бичгийг бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын дагуу боловсруулж, баталгаажуулан хэрэглээнд оруулсан.
- Хөтөлбөрийн үр дүн, цаашдын сажруулалтын асуудлаар аялал жуулчлалын байгууллагуудтай байнгын хамтын ажиллагаатай ажилладаг.

Анхаарах асуудал:

- Аялал жуулчлалын талаар Монгол улсын Засгийн Газраас баримтлах бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний дагуу төгсөгчийн загварын ур чадварын тодорхойлолтонд судлаачаас гадна “менежер-гүйцэтгэх ажилтны” ур чадварын шаардлагыг тусган шинэчлэн сайжруулах шаардлагатай.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Монгол улсын нийгэм-эдийн засгийн, түүний дотор аялал жуулчлалын салбарын хөгжлийн нөхцөл байдал, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг үндэслэн Хөтөлбөрийн төгсөгчийн загварыг илүү оновчтой тодорхойлж батлах.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- “Аялал жуулчлал” хөтөлбөрийн ХААИС-ийн захирлын 2017 оны 08 сарын 25-ны өдрийн А/183 тоот тушаалаар батлагдсан сургалтын төлөвлөгөөнд Заавал судлах 109 кредитийн 32 хичээлүүд, сонгон суралцах 15 кредитийн нийт 15 хичээлүүд багтсан байна. Хичээлийн хөтөлбөрүүдийг нэгдсэн нэг загварын дагуу боловсруулж, суралцагч төвтэй, онол, дадлагын зохистой харьцааг баримталсан байдлаар хичээлийг зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Сургалтын агуулга, суралцах орчин, багш нарын заах арга зүйн талаар оюутнуудаас судалгаа авч, судалгааны үр дүнг нэгтгэн тайлагнаж хэвшсэн. Хөтөлбөрийн онцлогоос шалтгаалан зарим хичээлүүдийн үнэлгээ хээрийн дадлага, биет байдлаар ArcGIS программаар гүйцэтгэх дасгал ажилбаруудаар тодорхойлогддог бөгөөд ерөнхий суурь болон мэргэжлийн суурь хичээлүүдийн хувьд аман, кейс судлал, эссе, илтгэл, тест, бичгийн шалгалт зэрэг хэлбэрээр явцын болон эцсийн шалгалтууд зохион байгуулагдаж байна.
- Сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүй, үнэлгээний системийн уялдааг хангах, хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор Агроэкологийн сургуулийн “Заах арга зүйн зөвлөл”-ийг ажиллуулж байгаагаас гадна хөтөлбөрийн агуулгыг зах зээлийн өнөөгийн нөхцөл, үйлдвэрлэлд тавигдаж буй шаардлагатай уялдуулан баяжуулж, шинэчлэн сайжруулж ирсэн. 2021 оны 4-р сард аялал жуулчлалын мэргэжлийн хамтын ажиллагааны гэрээтэй 15 байгууллага, салбарын төлөөлөл болох 10 байгууллагаас зорилтот бүлгийн ярилцлага хийн санал авч, сургалтын төлөвлөгөөг сайжруулах, дадлагын чанарт анхаарах болон багш нарын заах арга зүйг дээшлүүлэх, оюутны мэдлэг ур чадварыг сайжруулахын тулд хэрэгжүүлэх шаардлагатай нөхцөл байдлын судалгаа хийсэн байна.

Онцлог зүйл:

- Хөтөлбөрийн сургалтын төлөвлөлтийн баримт бичгүүдийг нэгтгэн *Аялал жуулчлалын хөтөлбөрийн иж бүрдэл* гарын авлагыг боловсруулан, багш, оюутнуудын хүртээл болгосон.
- Сургалтын төлөвлөгөөний хичээлүүд ба хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалт хоорондын хамаарлыг харуулсан сургалтын төлөвлөгөөний матрицыг боловсруулан хэрэгжүүлж байна.

Анхаарах асуудал:

- Төгсөгчид ба ажил олгогчдоос авсан судалгаа, шинжээчдээс газар дээр нь явуулсан ярилцлагын дүнгээс үзэхэд гадаад хэлний мэдлэг, чадвар сул хэмээн үнэлснийг анхаарч, сайжруулах.
- ОХУ-ын Томск, Эрхүүгийн их сургуулиудтай 2 хос хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр баталсан боловч хэрэгжүүлж эхлээгүй байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Англи хэлний сургалтыг аялал жуулчлалын мэргэжлийн англи хэлний багшаар заалгах болон мэргэжлийн хичээлүүдтэй уялдуулан сургалтын арга зүйг сайжруулах.
- Аялал жуулчлалын хос хөтөлбөрийн сургалтыг гадаадын их сургуулиудтай хамтран эхлүүлэх.

ШАЛГУУР 1-ИЙН ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан учлдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Аялал жуулчлал мэргэжлийн сургалтын төлөвлөгөөг 2017 онд батлуулснаас хойш албан ёсоор өөрчлөлт хийгээгүй боловч 2022 оны 11 сарын 3-ны өдрийн Агроэкологийн сургуулийн хөтөлбөрийн хорооны хурлын шийдвэрээр өөрчлөх саналыг ХААИС-ийн ерөнхий хөтөлбөрийн хороонд хүргүүлсэн байна. Харин сургалтын хөтөлбөрийн танилцуулгыг 2015 онд боловсруулаад 2018, 2021 онуудад нийт 2 удаа шинэчилсэн. Хамгийн сүүлд “Дээд боловсролын тухай хууль”-ийн 3.1, 3.2, 3.3 дугаар заалтууд, ХААИС-ийн Хөтөлбөрийн Хорооны журам”-ын 7.7, “Бакалаврын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө боловсруулах журам”-ын 3.1, Аж үйлдвэрийн IV хувьсгал, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, Хөтөлбөрийн оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааны тайланг үндэслэн ХААИС-ийн захирлын 2021 оны 04 сарын 20-ны өдрийн А/50 тоот тушаал, түүний хавсралтын дагуу АЭС-ийн Захирлын 2022 оны 03 сарын 28-ны өдрийн А/51 тоот тушаалаар батлагдсан хөтөлбөрийн баг “Аялал жуулчлал” мэргэжлийн хөтөлбөрийн шинэчлэлийг хийж 2022 оны 04 сарын 26-ны өдөр Мэргэжлийн Хөтөлбөрийн Хороогоор

хэлэлцэж, 2022 оны 05 сарын 06-ны өдөр АЭС-ийн Хөтөлбөрийн Хорооны хурлаар хэлэлцүүлсэн байна.

- 2021 оны 4 сарын 8-10-ны өдрүүдэд төрийн болон ТББ, хувийн хэвшлийн 15 төлөөлөгч, 12 ажил олгогч, 13 төгсөгчдийн төлөөлөлтэй хөтөлбөрийн талаар онлайнар фокус группын уулзалт хийж санал авсан байна. GAP шинжилгээг 2021.11-12 саруудад хийж гадаадын 4, дотоодын 5 их, дээд сургуулиудын аялал жуулчлалын мэргэжлийн хөтөлбөрүүдийг харьцуулан судалжээ.

Онцлог зүйл:

- Сургалтын хөтөлбөр нь бакалаврын сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангасан.
- Хөтөлбөр дэх сургалтын болон үйлдвэрлэлийн дадлагын багц цаг харьцангуй өндөр.
- Дадлагын талаар хамтран ажиллах гэрээ байгуулагдсан, дадлагын удирдамж, гурван талт гэрээ батлагдаж дадлага хийж хэвшсэн.
- Дадлагын хугацаанд эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалт болон дадлагын харьцуулалтыг гаргасан.
- Ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөрийг MONGWBL төслийн хүрээнд хэрэгжүүлж байгаа.
- Хөтөлбөрийн нийтлэг шаардлагын шинэчлэлийг сүүлийн 2015-2021 онуудад нийт 3 удаа хийсэн.
- Хөтөлбөрийн нийтлэг шаардлагын шинэчлэлийг хийхдээ суралцагчид, төгсөгчид, ажил олгогчид, хамтран ажилладаг байгууллагуудаас санал авч, үр дүнг тусгадаг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийг үр дүнд суурилсан боловсролын арга зүй (CDIO)-гээр боловсруулж хэрэгжүүлэх гэж буй тохиолдолд сайтар судлах шаардлагатай байна.
- Хөтөлбөрийн сургалтын агуулгыг боловсруулсан зарчим болон хичээлийн суралцахуйн үр дүнгийн матриц тодорхойгүй.
- Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэлийн хүрээнд дадлагын асуудалд илүү анхаарч бусад агуулгыг бага тусгасан.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн агуулгын шинэчлэлийг зорилго, зорилт, суралцахуйн үр дүн, хичээл хоорондын нягт холбоотой байдлаар хийж боловсруулах.
- Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг сургалтын шинэлэг арга зүйгээр (тухайлбал: үр дүнд суурилсан боловсролын арга зүй (CDIO) г.м.) цогц байдлаар боловсруулах.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь суралцагч төвтэй, хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан байна.

Илрэл нотолгоо:

- Боловсролын тухай хуулийн 45.1, 45.2, Дээд боловсролын тухай хуулийн 7, 8-р зүйл, ХААИС-ийн дүрмийн 8.1, Захиргааны Зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн “ХААИС-ийн сургалтын журам”-ыг шинэчлэн боловсруулсан бөгөөд энэхүү “ХААИС-ийн Сургалтын журам” болон “ХААИС-ийн

сургалтын үйл ажиллагааг зохицуулах удирдамж"-ийн дагуу "Аялал жуулчлал" хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагаа явагддаг.

- "Үр дүнд суурилсан сургалтын загвар"-ыг CDIO төслийн хүрээнд гаргасан гарын авлагад үндэслэн ХААИС-ийн Сургалтын Бодлого Зохицуулалтын Албанаас 2016 онд боловсруулсан бөгөөд "Аялал жуулчлал хөтөлбөрийн иж бүрдэл"-д сургалтын идэвхтэй арга зүйг тусган хэрэгжүүлж байна.

Онцлог зүйл:

- "Аялал жуулчлал" хөтөлбөрийн "Үр дүнд суурилсан сургалтын загвар" боловсруулсан.
- Хичээлүүдийн сургалтын заах, арга хэлбэрүүдийг гаргасан.
- Багш нарын заах арга зүйг төгсөгчдийн болон суралцагчдын өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээгээр голчлон тодорхойлдог.
- Хөтөлбөрт ордог зарим хичээлүүдийн дадлага хичээлийг танхим болон танхимаас гадуур хослуулан зохион байгуулдаг. Тухайлбал, Тусгай сонирхлын аялал жуулчлал, Монгол орны байгалийн газар зүй, Жуулчны аюулгүй байдал, даатгал г.м.
- Сургалтын төлөвлөгөөнд 6 кр цагийн 2 сургалтын дадлага, 6 кр цагийн 1 үйлдвэрлэлийн дадлага, нийт 12 кредит цагийн дадлага тусгагдсан нь зүйтэй байна.

Анхаарах асуудал:

- Сургалтын арга зүйд хийсэн дүн шинжилгээ тодорхойгүй.
- Тайланд бичсэнээр оюутны болон төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаагаар багшийн сургалтын арга зүй, мэдлэг, ур чадвар шаардлага хангаж буй талаар дүгнэж, судалгааны арга зүйг хөгжүүлдэг гэсэн нь өрөөсгөл байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Цогц чадамжид суурилсан сургалтын арга зүйг илүү тодорхой болгох.
- Сургалтын үйл ажиллагааны хүрээнд авсан олон талт санал асуулгуудын үр дүнгийн хүрээнд цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, стратеги төлөвлөлт боловсруулж, үр дүнг тооцох, хөтөлбөрийг сайжруулахад ашиглах шаардлагатай.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын бодлого зохицуулалтын албанаас CDIO төслийн хүрээнд гаргасан "Сургалтын явцын үнэлгээг шинэчлэх, сургалтын хөтөлбөрт нэгдсэн үнэлгээ хийх арга зүйн зөвлөмж"-ийн дагуу суралцахуйн үр дүнгүүд болон сургалтын үйл ажиллагаанд тасралтгүй сайжруулалт хийж байх зорилгоор үнэлгээний шинэлэг системийг нэвтрүүлсэн байна.
- Суралцагчийн үнэлгээний системийг ХААИС-ийн Захирлын 2022 оны 07 сарын 05-ны өдрийн А/194 тоот тушаалаар батлагдсан бакалаврын Сургалтын журмын 2.34, 2.35, 2.36, 2.37, 2.38, 2.39, 6-р зүйл, Хөтөлбөрийн боловсролын зорилго, зорилтууд, суралцахуйн үр дүнгүүдийг тодорхойлох арга зүйн зөвлөмж, Сургалтын явцын үнэлгээг шинэчлэх, сургалтын хөтөлбөрт нэгдсэн үнэлгээ хийх арга зүйн зөвлөмжид заасны дагуу суралцагчийг үнэлж дүгнэдэг.

Онцлог зүйл:

- Оюутны мэдлэг, чадварыг үнэлэх журамтай. Тодорхой хугацаанд шинэчлэгдэж байдаг.
- Үнэлгээтэй холбоотой оюутны сэтгэл ханамжийн судалгааг жил бүр авдаг.
- Үнэлгээнд рубрик аргыг ашигладаг.
- Төгсөгчдийн голч дүнгийн судалгаа хийгдсэн.
- Үнэлгээтэй холбоотой төгсөгч болон оюутны сэтгэл ханамжийн судалгаа авч дүгнэсэн.

Анхаарах асуудал:

- Сургалтад ашиглаж буй үнэлгээний арга зүйн судалгаа хийгдээгүй.
- Хичээл нэг бүрийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ байхгүй (нэг хичээлээр жишээ авч үнэлгээний анализ хийх боломжтой байсан).
- Шалгалтын хэлбэр, сорилын санд хийсэн дүн шинжилгээ байхгүй.
- Хөтөлбөрөөр суралцагчдын үнэлгээний амжилт, чанарыг тооцсон судалгаа байхгүй.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Хичээл тус бүрээр, цаашид хөтөлбөрийн үнэлгээг хийх.
- Шалгалт, сорилын санд тогтмол үнэлгээ хийж, сайжруулах, дүн шинжилгээ хийх.

ШАЛГУУР 2-ИЙН ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалт явуулах анги танхим болон багшийн ажиллах орчны стандартыг хангаж байна. Үүнд: Анги танхим, лабораторийн нэг оюутанд ногдох стандарт 2.5м²-аас их байх, багш нарын өрөөний стандарт 1-ээс доошгүй байх
 - Аялал жуулчлал хөтөлбөрийн сургалтад хичээл зааж буй багш нарт 2017 онд өрөө тасалгааны талбайн хангамж нэг хүнд 6.4 м², Байгалийн аялал жуулчлалын нэг бакалаврын оюутанд оногдох хичээлийн танхим 3,92 м² байсан бол нэг өрөөнд суух багшийн тоо буурсан, элсэн суралцагч оюутны тоо буурсантай холбогдон 2021 онд нэг багшид ногдох өрөө 7.7 м² болж өсөж, нэг бакалаврын оюутанд ногдох хичээлийн танхим 7,45м² болж өссөн байна Хөтөлбөр хэрэгжүүлэх экологийн тэнхимийн 16 багш эрхлэгчээс гадна 4, 4-рөө суух нийт 4 өрөөтэй байгаа нь дунджаар нэг багшид ногдох 6.25м² байна.
- Сургалт явуулах хөтөлбөрт хамаарах анги, танхим, лабораторийн тоо нэмэгдэж, шинэчлэлт хийгдсэн ба багаж хэрэгслээр хангагдсан байна. Үүнд:*
- Аялал жуулчлал хөтөлбөрийн сургалтад лекцийн 4, семинар, дадлагын 8, сургалт судалгааны 7 лаборатори сургалтад ашиглагдаж байна. Үүнд, №330 тоот

танхимыг MONGWBL төслийн буцалтгүй тусламжаар суурин 20 компьютер бүхий нэг лаборатори шинээр байгуулагдаж, тухайн хөтөлбөрт бүрэн ашиглагдаж байна. №226 тоот танхимыг дижитал лабораторийг англи хэлний хичээлүүдийн сургалтад ашиглаж байна. №246 тоот танхимыг геомэдээллийн лаборатори нь газар зүйн мэдээллийн систем, тандан судалгааг програм дээр зааж сургалт явуулж байна. Долоо хоногт 1 удаа 2 академик цагаар нэг ангид хичээл орох хуваарьтай байгаа нь танхим ашиглалт хэвийн байгааг харуулж байна.

Онцлог зүйл:

- Ажлын байранд суурилсан сургалтыг хэрэгжүүлж буй сайн туршлагатай холбогдон сургалтын орчин сайжирч байна.
- Цаашид шинэ номын сан баригдсантай холбоотойгоор зарим багш нарын өрөөнүүд суларч, тэдгээрийг оюутнуудын сургалт, судалгаа болон бие даах, багаар ажиллах орчин сайжруулах ажлууд төлөвлөгөөний дагуу хийгдэж байна.

Анхаарах асуудал:

- 1 давхрын зарим анги танхимын ширээ сандал, сургалтын хэрэглэгдэхүүн хэт хуучирсан байгааг анхааран сольж шинэчлэх, энэ нь сургалтын байрыг биечлэн үзэх явцад ажиглагдсан. Мөн төгсөгчдийн төлөөлөлтэй уулзаж ярилцахад бас энэ асуудлыг ярьж байсан тул анхаарах.
- Хичээлийн бус цагаар хоосон анги танхимыг оюутнуудыг бие даан сурахад ашиглах, бүхий л боломжит хугацаанд тохирсон анги танхим, лаборатори, багаар ажиллах орчин бүрдүүлэх, оюутнуудад хүртээмжтэй болгох.
- Өрөөнүүд хүйтэн, цонх, салхивчтай ч агааржуулалт муу байгааг сайжруулах, энэ нь суралцагч, төгсөгчийн уулзалтын үеэр мөн гарсан саналуудаар нотлогдсон.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Хичээлийн бус цагаар хоосон анги танхимыг оюутнуудыг бие даан сурахад ашиглах боломжоор хангасан талаар өөрийн үнэлгээний тайланд тусгасан ч, үүнийг биежүүлж, албажуулахад анхаарах, тухайлбал, бие даан сурах анги танхим, лаборатори, багаар ажиллах орчин бүрдсэн анги танхим, лабораторийн хуваарийг гаргаж, оюутнуудад хүртээмжтэй болгох төлөвлөгөө гарган биелэлтэд анхаарч ажиллах.
- Өрөөний халаалт, агааржуулалтын хоолой, агаар сэлгэлтийг сайжруулан, дулаан алдагдлыг бууруулан, хэт хуучирч ашиглалтын хугацаа дууссан, сургалтын стандарт хангахгүй ширээ сандлыг шинэчлэн, анги танхимын суралцах орчинг сайжруулах.
- Сургалтын орчны сэтгэл ханамжийн судалгааг тогтмолжуулах, ялангуяа судалгааны үр дүнгээр сайжруулалт хийдэг болоход анхаарах.
- Багшийн ажиллах орчин хангагдсан талаар судалгаа байхгүй, судалгаатай болон түүний үр дүнгээр багшийн хэвийн аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд юунд анхаарах, юуг засч сайжруулахыг тодорхойлох анхаарах боломжтой.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

Сургалт судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл болон материалаар хангаж байна. Үүнд:

- Аялал жуулчлалын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын хэрэглэгдэхүүнд газар зүйн мэдээллийн системийн ArcGIS10.1-10.8, нээлттэй эх үүсвэрийн QGIS8, дүрс мэдээ болосвруулах ENVI5, ErdasImagine14, төлөвлөлт, зураглалын Autocad14, SPSS, KW hotel зэрэг программуудыг зарим нь албан ёсны эрхтэй ашиглаж байгаа бөгөөд программуудын лиценз, сунгалтыг ажил олгогч (МонМэпХХК)-ийн дэмжлэгээр хийн сургалтад ашигласан, цаашдын сунгалт нь дууссан бол зарим нь крак хувилбар бүхий программуудыг ашиглаж байна.
- Сургалтын хэрэглэгдэхүүнд биет үзүүлэн, макет цаасан болон тараах материал ашиглахын зэрэгцээ ажлын байранд суурилсан сургалтын давуу талыг шингээсэн дадлагын хичээлийн материалуудыг ашиглаж байна. Хөтөлбөрөөр суралцах оюутны тоо буурсан тул сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмж нэмэгдсэн.
- Сургалтанд ашиглах лабораторийг төслөөр байгуулсан тул №330тоотод тус хөтөлбөрийн оюутнууд илүү төвлөрч суун ажилладаг.
- Өөрийн үнэлгээний тайланд онлайн технологи ашигласан холимог сургалт явуулж буйг дурьдсан ч тус хөтөлбөрт хэрэгжүүлж буй хос хөтөлбөр байхгүй байгааг оролцогчидтой хийсэн уулзалт ярилцлагын үеэр тодруулсан.
- COVID19-ын үед цахим сургалтыг google classroom хэлбэрээр явуулсан, энэхүү талбарт хичээлийн лекцийн ppt, семинарын материал, шалгалт, бие даалтуудыг авч байсан боловч тэнхимийн нэгдсэн сан гэж үүсгээгүй байна. Мөн цахим журнал хөтлөлт, оюутан сургалтын явцад өөрийн үнэлгээгээ хянах, эргэх холбоотой байх сургалтын мэдээллийн технологи хангалтгүй бүрэн хангалттай бус байгааг уулзалтын үеэр тодруулсан.
- ХААИС-ийн Захирлын 2020 оны11 сарын 27-ний өдрийн А/167 тоот тушаалаар батлагдсан журамд цахим хичээлийн агуулгад тавигдах шаардлага, цахим хичээлийн технологид тавигдах шаардлагад аудио, видео + google classroom, google meeting, zoom зэрэг хэлбэрийг ашиглах гэсэн, цахим сургалтыг зохион байгуулах нэгдсэн платформтой байх, нэгтгэсэн бааз датаа бүрдүүлэхийг тус тус тусгасан.

Онцлог зүйл:

- Хөтөлбөрийн онцлогт тохирсон сургалтын програм ашигладаг нь оюутнуудын идэвх сонирхлыг нэмэгдүүлдэг, сургалтын чанарт эерэгээр нөлөөлж байгаа нь суралцагчидтай хийсэн ярилцлагын үеэр нотлогдсон. Тухайлбал, Газар зүйн мэдээллийн системийн программыг ашиглан байгалийн аялал жуулчлалын хичээлийг явуулдаг нь оюутнуудын тухайн хөтөлбөрийг суралцах сонирхлыг төрүүлдэг сургалтын хэрэглэгдэхүүн болон хэвшсэн.
- Ажлын байрны сургалтын арга зүй, хэрэглэгдэхүүнийг дадлагын хичээлд ашигладаг болсон зэрэг туршлагууд нь уг хөтөлбөрийн давуу тал болж байна. Мөн холимог сургалтыг явуулах боломжийг бүрдүүлсэн байна.

Анхаарах асуудал:

- Цахим сургалтын стандарт хангалтгүй буюу баримт бичгийн бүрдэлтэй танилцах үед болон оролцогч талуудтай хийсэн ярилцлагын үеэр гарсан саналуудаар нотлогдож байна. Үүнд, өөрийн цахим платформгүйтэй холбогдон цахим хичээлийн талбар, контент

хөтөлбөрийн түвшинд тэтгэвэртээ гарсан багшийн бэлтгэсэн Youtube бичлэгээс бусдаар бүрэн бус буюу цахим орчны ашиглалт, хүртээмж хангалттай бус байна. Тухайлбал, цахим лекцийн видео бичлэг сургалтаас өмнө талбарт байршуулдаггүй, хичээл бататгасан хэлэлцүүлэг хийсэн бичлэг байхгүй, багшийн конспектоос бусад цахим унших болон нэмэлт материал хангалттай тавигдаагүй, цахимаар ашиглах эх сурвалжийн линк өгөгдөөгүй зэрэг ажиглагдлаа.

- Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмжийг сайжруулахтай холбогдуулан тусгайлан авдаг давтамжит судалгаа байхгүй.
- Сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмж, ашиглалтын талаар давтамжтай нарийвчилсан судалгааг багш, оюутнаас тасралтгүй авч, судалгааны үр дүнгээр сайжруулалт хийгддэг эсэх нь бүрэн нотлогдоогүй.
- Е-контент түвшинд боловсруулсан сургалтын материал хангалтгүй байгаад анхаарч, сайжруулах.

Үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Зөвлөмж:

- Сургалтын хэрэглэгдэхүүний, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгааг чанаржуулах, судалгааны үр дүнгээр сайжруулалт хийдэг байх, сайжруулалт хийснээ дүгнэн оруулдаг тасралтгүй циклийг бий болгох.
- Цахим сургалтын хэрэглэгдэхүүнийг хөгжүүлж, сургалтад бүрэн ашиглах.

Шаардлага:

- Сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмж, ашиглалтын талаар давтамжтай нарийвчилсан судалгааг багш, оюутнаас тасралтгүй авч, судалгааны үр дүнгээр сайжруулалт хийх.
- Е-контент түвшинд боловсруулсан сургалтын материалыг сайжруулах.

3.3. Сурах бичиг, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн номын сан цахим номын сан болох зорилгын хүрээнд ном сурах бичгийг цахим хэлбэрт оруулсан бөгөөд тус сургуулийн электрон каталогт нийт 50064 төрлийн 187618 ширхэг материал бүртгэгдсэн байна.
- Дижитал номын сангийн технологийн үйлчилгээг ХААИС-ийн түвшинд нэвтрүүлсэн боловч хөтөлбөрийн оюутнууд хэрэглээ дутмаг байгаа нь ярилцлагын үеэр гарсан. Тухайлбал, цахим сургалтын үед хөтөлбөрийн номнуудыг цахимаар үзэхэд хязгаарлалттай байсан.
- 2012, 2017, 2019 онуудад бүрдүүлсэн мэргэжлийн 375 ном сурах бичгийг мэргэжлийн ангийн оюутнуудад болон сургалтад үнэ төлбөргүй ашиглаж байна.
- ХААИС-ын номын сантай танилцах үед тус хөтөлбөрийн мэргэжлийн нэг тавиур дээрх номнуудаар оюутнуудад заалаар үйлчилж байна, харин дижиталаар үйлчлэх цахим номын сангийн үйлчилгээ болон баяжилт мэргэжлийн номны хувьд дутмаг байна. Энэ нь

ном ашиглалт, номын эрэлт хэрэгцээг гаргах судалгаа хөтөлбөрийн болон Агроэкологийн сургуулийн хувьд хангалтгүй байгаатай холбоотой байна.

- Эрдэм шинжилгээ судалгааны фондоос хөтөлбөрийн судалгааны мэдээлэл зөвхөн цөөн хүрээлэнгүүдээс гарсан сэтгүүлийн түвшинд байгаа ба мэргэжлийн багш нарын номноос өөр баяжуулалт, шинэчлэлт хийгдээгүй байна.

Онцлог зүйл:

- Номын сангийн үйлчилгээ, хүртээмж нь шинэ номын сантай болсонтой холбогдон сайжирч, уншлагын төрөлжсөн заалыг үйлчилгээнд нэвтрүүлсэн байсан.

Анхаарах асуудал:

- Судалгааны материалын **хуулалтын түвшин шалгадаггүй**, судалгааны бүтээлүүдийг үнэ цэнгүй болгож байгаа нь уулзалтын үеэр гарсан.
- Цахим ном ашиглалт, эргэц, түүний судалгаа шинжилгээг тогтмолжуулж, байгалийн аялал жуулчлалын хөтөлбөрийн түвшинд цахим мэргэжлийн номтой болох.
- Мэргэжлийн түлхүүр сурах бичиг, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт, сэтгэл ханамжийн судалгаа хангалтгүй, түүнд хийсэн шинжилгээ дүгнэлт байхгүй.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой мэдээллийн нээлттэй эх үүсвэрийн хэрэглээ ХААИС-ийн түвшинд байгаа ч, хөтөлбөрийн түвшинд оюутнууд хангалттай авч ашигладаггүй нь ярилцлагын болон биет үзлэгийн үеэр нотлогдсон. Ялангуяа, цахим сургалтын үед хөтөлбөрийн хичээлүүдийн материал дотор нээлттэй эх үүсвэр ашиглах талаар тусгагдаагүй байсанг анхаарах. www.legalinfo гэх мэт цөөн хууль эрх зүйн линк тавьсанг мэргэжлийн хичээлүүдийн ном сурах бичиг, нэмэлт материалын эх үүсвэр гэж үзэхэд хангалтгүй байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Багш судлаачдын эрдэм шинжилгээний судалгаа, ном сурах бичиг, бүтээл гаргах ажлыг дэмжих.
- Байгалийн аялал жуулчлалын хөтөлбөрийн мэргэжлийн цахим номыг оюутнуудад ашиглуулдаг болох.
- Цахим мэдээллийн сан, дижитал номын сан, нээлттэй эх үүсвэр ашиглалтын судалгааг тогтмолжуулах, 2019 оноос хойш мэргэжлийн ном сурах бичгийн баяжилт, шинэчлэлт хийгдээгүй байгаа тул баяжуулж, шинэчлэх.
- Мэдээллийн нээлттэй эх үүсвэрийн байдлыг хөтөлбөрийн мэргэжлийн хичээлүүдийн хувьд илүү түлхүү анхаарч оруулах.

ШАЛГУУР 3-ИЙН ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- “Дээд боловсролын тухай хууль”-ийн 5.1-д “Дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн нэгж нь тэнхим, лаборатори байна. Их сургууль нь профессорын багт тулгуурласан зохион байгуулалтын нэгжтэй байж болно” гэж заасны дагуу ХААИС-ийн захирлын 2014 оны А/202 тоот тушаалаар Агроэкологийн сургуулийн бүтцийн нэгжийг 4 тэнхимтэй болгосон. Энэхүү шинэ бүтцээр Экологийн тэнхимд аялал жуулчлалын хөтөлбөрийг нэгтгэж, тухайн хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэж байна.
- Аялал жуулчлалын хөтөлбөрийг ХААИС-ийн бакалаврын сургалтын журам (ХААИС-ийн Захирлын 2016 оны 07-р сарын 28-ны өдрийн А/153 тоот тушаал), ХААИС-ийн Хөтөлбөрийн хорооны журам (ХААИС-ийн Захирлын 2015 оны 11-р сарын 24-ний өдрийн А/377 тоот тушаал)-ын дагуу Хөтөлбөрийн ерөнхий хороо, Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороо, мэргэжлийн хөтөлбөрийн хороо гэсэн үе шаттайгаар удирдан зохион байгуулж байна.

Онцлог зүйл:

- Аялал жуулчлалын мэргэжлийн хөтөлбөрийн хорооны одоогийн бүрэлдэхүүнийг дээрх удирдлага зохион байгуулалтын дагуу Хөтөлбөрийн хорооны журмын 6-д заасан хөтөлбөрийн хорооны гишүүдэд тавигдах шаардлагуудыг харгалзан үзэж АЭС-ийн захирлын 2021 оны 03 дугаар сарын 09-ний А/16 тоот тушаалаар баталсан.
- Мэргэжлийн хөтөлбөрийн хороо жилд тогтмол 5-аас дээш удаа хурал хийж, үйл ажиллагаагаа хурлын тэмдэглэлээр баталгаажуулдаг. Мэргэжлийн хөтөлбөрийн хорооны хурлаар сургалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах, өвөл, хаврын төгсөлтийн үйл ажиллагаа, сургалт болон үйлдвэрлэлийн дадлага хамгаалуулах зэрэг ажлыг хэлэлцэж, хурлын тэмдэглэл хөтөлж, Google classroom-д үйл ажиллагааны төлөвлөлт, хурал, улсын шалгалт, сургалтын болон үйлдвэрлэлийн дадлагын тайланг байршуулах, үйл ажиллагааг зохион байгуулах ажлыг хийдэг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад сургалтын төлөвлөгөө, сургалтын үйл ажиллагаа, багш нар хичээлийн стандарт харах, дүн оруулах, цалингийн мэдээлэл харах, цагийн тооцоо хийх зэрэг ажиллагаанд удирдлагын мэдээллийн системээ (<https://teacher.muls.edu.mn>) бүрэн ашиглах.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Сургалтын болон сургалтыг дэмжих программуудаа нэгтгэх, ашиглалтыг сайжруулан мэдээллийг тухай бүр шинэчлэх.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг

ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- 2023 он дуустал ERASMUS-ийн төслийн санхүүжилттэй MONGWBL төсөлтэй хамтарч аялал жуулчлалын хөтөлбөрийг ажлын байранд суурилсан сургалтыг явуулсан. Уг төслийн явцын 2 тайлан бичиж хүргүүлсэн байсан.
- Орлоцогч талуудтай хамтарсан тасралтгүй үйл ажиллагаанууд явагддаг, үүнд Grand tour олимпиад, хамтарсан эрдэм шинжилгээний хурал, олон тэмцээн уралдаан зэргийг зохион байгуулдаг нь өөрийн үнэлгээний тайланд тусгагдсан.
- Гадны их сургуулиудтай 2 хос хөтөлбөр, 2 ЭШ хурлын хүрээнд хамтрахаар ажиллаж эхэлж байна.
- Япон улсад дадлагажих оюутан солилцооны интерншип хөтөлбөрийг хэрэгжүүлж дууссан байсан баримттай танилцахад гэрээ байсан, гэрээг дүгнэсэн болон хамтарсан солилцооны тэтгэлэгт хөтөлбөрийн үр дүнг гаргаагүй байсан.
- Хөгжлийн бэрхшээлтэй нэг оюутанд 500,000₮-ийн тэтгэлэг олгосон болон дэмжсэн баримттай танилцсан. Уг оюутантай уулзалт хийхэд энэ талаар давуу тал болгож ярьсан.
- Өөрийн үнэлгээний тайланд Google form апп ашиглан 81 төгсөгчдөөс судалгаа авсан нь биет байдал дээр 45 төгсөгчөөс авсан судалгаатай. Ажил олгогч, төгсөгчдийн уулзалт ярилцлагын үед төгсөгчид хэлний ур чадвар дутмаг, мэдээлэл технологийн дэвшилтэт технологийг ашиглах ур чадвар дутмаг байгааг онцолсон.
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг тасралтгүй сургалт хөгжил, мэдээлэл болон ажлын байранд өөрсдийгөө сайжруулах хөгжүүлэх хэрэгцээ байгааг хэлж байсан.

Онцлог зүйл:

- 2023 он дуустал MONGWBL төсөлтэй хамтарч аялал жуулчлалын хөтөлбөрийг ажлын байранд суурилсан сургалтыг явуулж, сургалтын төлөвлөгөөний загвар боловсруулсан.

Анхаарах асуудал:

- Хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн ажлын тайлан, үр дүнг тайлагнадаг байх.
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний ажлуудыг явуулж байгаа хэдий ч хамрагдагсдын тоо, үр дүн, ажлын тайлан, дүгнэлтийг багш суралцагсдын зүгээс гаргасан нэгтгэсэн мэдээ файл байгаагүй.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Нийгэмд үзүүлсэн тодорхой ажлуудыг цаашид тогтмолжуулах, тайлан мэдээг нийтийн хүртээл болгон, цаашид сургалт судалгаандаа ашигладаг байх.
- Төгсөгчдөөс санал авч ажлын байранд нь давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг Төгсөгчдийн холбоотой хамтран зохион байгуулах.

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн удирдах зөвлөлийн 2013 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн хурлаар батлагдсан “Монгол Улсын ХААИС-ийн дүрэм”-ийн 5.12.5-д заасны дагуу АЭС нь тухайн жилийн төсвөө урьдчилан тооцож, Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэн, ХААИС-ийн Нийгэм, эдийн засгийн албаны дэд захирлаар батлуулан дагаж мөрддөг. Сургалтын материаллаг баазыг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг шинэчлэхэд шаардлагатай зардлыг жил бүрийн төсөвт тусгадаг. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын төсвийг тухайн жилийн инфляц, суралцагчдын тоо, багш ажилтны тоо, зардлын үзүүлэлтүүдийг зүйл бүрээр тооцож ХААИС-ийн хэмжээнд нэгтгээд БШУЯ, Сангийн Яамаар хянуулж баталгаажуулдаг.
- АЭС нь ХААИС-ийн бусад бүрэлдэхүүн сургуулийн адилаар санхүү, нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартын дагуу явуулдаг бөгөөд Unicus программаар орлого зарлагын гүйлгээг иж бүрэн бүртгэж, тайлан балансыг жилд 4 удаа гарган Санхүүгийн албаар хянуулан ил тод тайлагнаж, БШУЯ-нд хүлээлгэн өгдөг тогтолцоотой.
- Санхүүгийн зарлагын талаар АЭС-ийн Захирлын зөвлөлөөр хэлэлцэж шийддэг. Жил бүрийн төсвийг хуваарилж, Захирлын зөвлөлөөр хэлэлцсэний дараа ХААИС-ийн Захирал батална. Томоохон засвар, тохижилтын ажилд тендер зарладаг. Дотоод аудитыг санхүүгийн жилдээ багтааж, харин гадаад аудитыг жил тутамд хийлгэдэг. Өмнөх жилүүдэд аудитын зөрчилгүй дүгнэлттэй тайлан гарч байсан хэдий ч 2021 онд хязгаарлалттай дүгнэлттэй гарсан нь сургалтын гол хэрэглэгдэхүүн болох ном сурах бичгийн бүртгэл дутуу бүртгэгдсэнг илрүүлж зөвлөмжинд тусгасан байсан. 2022 онд 9,037,000 төгрөгний ном худалдан авалт бүртгэсэн ба энэ дүнгээр номын фонд бүртгэлтэй. Өөрөөр хэлбэл, 2020 оноос өмнөх тухайн хөтөлбөрийн сургалтад ашиглаж буй 375 ном болон бусад ном сурах бичиг нь номын бүртгэл санхүүгийн тайланд тусгагдаагүй, мөн тэнхимийн номын жагсаалтаар 2020 оны хүртэлхийг гараар бүртгэснээс хойш дахин шинэчилж, бүртгэлжүүлж баяжуулаагүйгээс харагдаж байна.
- Аялал жуулчлал хөтөлбөрийн сургалтын төлбөр дунджаар 3181350 төгрөг байгаа нь сургуулийн дунджаас дээгүүр үзүүлэлт бөгөөд 2019 оноос 2022 онуудад сургалтын төлбөр нэмэгдээгүй боловч 2022-2023 оны хичээлийн жилд дунджаар 31 хувиар өссөн байна. Сургалтын өртөг, зардлын өсөлтийг дагаж сургалтын төлбөр өссөн тооцоо судалгаа байхгүй. Сургалтын өртөг нэг оюутны дунджаар тооцсон ч сургалтын төлбөрийг нэг кредитийн үнэлгээгээр тооцсон байна.
- Хөтөлбөрийн санхүүжилтийн гол эх үүсвэр нь сургалтын төлбөрөөс бүрддэг.

Онцлог зүйл:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн удирдлага нь сургалтын шинэ арга зүйг нэвтрүүлэх, багш нарын бичсэн ном, сурах бичгийг хэвлүүлэх, багш нарын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах зэрэгт тодорхой санхүүжилтийг авдаг байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх боловсролын жилийн төсөв, гүйцэтгэлийн тайлан, түүнд хийсэн дүн шинжилгээ, засч сайжруулсан мэдээллээр хангадаг байх.
- Нэг суралцагчид ногдох өртөг зардлын тооцоо үндсэндээ худлаа гарсан. Тухайлбал, нийт зардлаа сургалтын ба сургалтын бус, хөрөнгө оруулалтын гэж ангилаад оюутны нийт тоонд хувааж дундаж зардлыг тооцсон. Дургүй хичээлийг өндөр кредитээр хүчээр сонгомооргүй байна гэсэн саналыг гараад байгаатай холбоотой гэж үзэж байна.
- Санхүүгийн ил тод байдал хангалтгүй, аудитын тайлан, зөвлөмжийг Агроэкологийн сургуулийн түвшинд авч тусгаж ажилладаг тодорхой бус.

- Ном сурах бичиг үндсэн хөрөнгийн бүртгэл мэдээлэл санхүүгийн бүртгэл дутуу.
- Сургалтын гол хэрэглэгдэхүүн болон ном сурах бичиг, сэтгүүл, эрдэм шинжилгээний бүтээлүүд нь үндсэн хөрөнгийн бүртгэл мэдээлэл санхүүгийн бүртгэл дутуу.
- Хөгжлийн үзүүлэлтүүдэд санхүүгийн шинжилгээний тооцоог ашиглах, үр дүнг удирдлагын шийдвэр гаргалтанд ашигладаг байх.

Үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Зөвлөмж:

- Боловсрол олгох үйл явц, боловсролын түвшний ялгаатай байдлаар сургалтын төлбөр, нэг кредитийн үнэлгээг эзэмшүүлж буй мэдлэг чадвар дадал буюу чадамжид тулгуурлан тогтоох, тухайлбал, суурь хичээлүүд, мэргэжлийн хичээлүүд, мэргэшүүлэх хичээлүүд болон дадлагын үнэлгээг ялгаатай тогтоох нь сургалтын чанар, оюутны суралцах идэвхид сайнаар нөлөөлнө.

Шаардлага:

- Аялал жуулчлалын хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэсэн шинэчлэлт, өөрчлөлтөнд зориулсан төсөв, түүний гүйцэтгэл, дүн шинжилгээг тогтмол хийдэг байх.
- Хөтөлбөрийн санхүүжилт, орлого, зардлын тооцоог ил тод байлгах. Тухайлбал, сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүнгийн судалгааг гаргадаг байх.
- Хөтөлбөрийн санхүүжилтийн олон эх үүсвэртэй болох, мөн хөтөлбөрт олгож буй төр хувийн хэвшлийн дэмжлэг, санхүүжилтийн зарцуулалтыг тогтмол тайлагнадаг байх.
- Хөтөлбөрөөр суралцагчдын өртөг, үр ашгийн тооцоог тогтмол хийдэг байх.
- Нэг кредитийн өртгийг боловсролын үйлдлээр тооцож, сургалтын үнэлгээг уялдуулан тогтоодог байх.
- Сургалтын хэрэглэгдэхүүний бүртгэл бүрэн гүйцэт тусгагддаг байх.
- Багшийн хөгжлийн төсөв, түүний зарцуулалтын тайлан мэдээ, үр дүнг тайлагнадаг байх.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- 2015-2017 онд ХААИС-ийн маркетингийн идэвхжүүлэлтийн хөтөлбөрийг батлан хэрэгжүүлсэн.
- ХААИС-нь жил бүрийн хавар элсэлтэд зохиулан маркетингийн хөтөлбөрийг батлан гаргадаг. Энэ хөтөлбөрийн хүрээнд бүрэлдэхүүний сургууль, хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхим, мэргэжлийн багш нарын элсэлтийн комисст ажиллаж, сургууль, хөтөлбөрөө сурталчлан ажилладаг.
- Элч оюутныг өөрийн хүсэлтээр нь сонгодог. Жил бүр элсэлтийн үйл ажиллагаатай холбогдуулан элч оюутны ажиллах удирдамжийг батална. Элч оюутан нь өөрийн нутагтаа элсэлтийн сурталчилгааг хийж өөрт хуваарилагдсан томилолтоор оюутан элсүүлэх эрхтэй ажилладаг байна.
- Жил бүр БШУЯ-наас зохион байгуулагддаг боловсролын яармаг үзэсгэлэнд идэвхтэй оролцож мэргэжлээ сурталчлахаас гадна сурталчилгааны танилцуулгыг шинэчлэн сайжруулдаг.

Онцлог зүйл:

- Хөтөлбөрт элсэх боломжтой элсэгчийн тоог ЕБС-ийн төгсөгчдийн тоотой харьцуулан анализ хийсэн.
- Элсэлтийн үйл ажиллагааг маркетингийн олон хэлбэрийг ашиглан зохион байгуулдаг.
- Тус сургуулиас элч оюутан, элсэлтийг орон нутагт зохион байгуулах багш нарыг томилон ажиллуулж, боловсролын үзэсгэлэн, веб, нийгмийн сүлжээнд түшиглэсэн сурталчилгаа, тараах материал, самбар байршуулах зэрэг олон талт маркетингийн үйл ажиллагааг явуулдаг.
- Хөтөлбөрийн маркетингийн үйл ажиллагаанд “Элч оюутан” гэх үйл ажиллагааг тогтмол ашигладаг.

Анхаарах асуудал:

- Элсэлттэй холбоотой маркетингийн үйл ажиллагааны үр дүнг тооцож, цаашдыг үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэх төлөвлөгөө байхгүй.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- ХААИС-ийн маркетингийн идэвхжүүлэлтийн хөтөлбөрийн дагуу бүрэлдэхүүний сургууль, мэргэжлийн тэнхим стратегийн төлөвлөлт хийж хэрэгжүүлэн ажиллах.

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн түвшинд мэдээллийн ил тод байдал сайн (ХААИС-ийн үндсэн веб сайт <https://muls.edu.mn>, АЭС-ийн цахим хуудас <https://agroecology.muls.edu.mn> болон олон нийтийн хамгийн түгээмэл хэрэгсэл болох фейсбүүкийг өргөн ашиглаж байна).
- Агроэкологийн сургуулийн web дотор аялал жуулчлалын хөтөлбөрийн мэдээлэл дутмаг буюу page хуудас ажиллахгүй байсан.
- Вэбсайтын мэдээллийн тогтмол үйл ажиллагаа хангалттай бус, тухайлбал 2020 оны 5 сараас 2022 оны 4 сар хүртэл мэдээллээ шинэчлээгүй.
- Аялал жуулчлал хөтөлбөр нь видео танилцуулгатай боловч харин цахим ном, цахим сонин сэтгүүл, брошур дутмаг.

Онцлог зүйл:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч ерөнхий удирдлагын мэдээллийн систем хөгжсөн.
- Вэбсайтын агуулга мэдээллийн иж бүрэн байдал сайн.
- Хөтөлбөрийн талаар видео танилцуулга бүхий сурталчилгааг ил тод нээлттэй ашигладаг.

Анхаарах асуудал:

- Аялал жуулчлалын хөтөлбөрийн хувьд сургалтын албаны шилэн самбарын ажиллагааг сайжруулах.
- Оролцогч талуудыг хөтөлбөрийн талаарх нээлттэй мэдээллээр хангах тасралгүй системийн хөгжүүлэлтийг сайжруулах.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Зөвхөн фейсбүүк зэрэг албан бус мэдээллийн хэрэгсэл ашиглаж мэдээлэл түгээхээс илүүтэй өөрийн платформ системийг хөгжүүлэх.

ШАЛГУУР 4-ИЙН ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: БҮРЭН ХАНГАСАН**Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйлчилгээ**

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Их, дээд сургуульд оюутан элсүүлэх нийтлэг шаардлагын дагуу оюутан элсүүлэн авдаг.
- ХААИС-ийн албан ёсны цахим хуудсаар, мөн профессор багш нарын зурагт, радиогийн ярилцлага, сайтуудад мэдээ, элсэгчдэд зориулсан Элсэлт-2020, Элсэлт-2021, Элсэлт-2022 зэрэг нүүрийн номын бүлгэмээр сургууль, тэнхим, мэргэжил сурталчилдаг.
- ХААИС-ийн Захирлын 2019 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/140 тоот Элсэлтийн маркетинг төлөвлөгөө хэрэгжүүлэх тухай тушаалын дагуу АЭС-ийн захирлын тушаалаар 2018 онд 9, 2019 онд 10, 2020 онд 7 багш элсэлтийн комисст Улаанбаатар хот болон аймгийн төвүүдэд ажилласан байна. БШУЯ-ны Боловсролын үзэсгэлэн яармагт тайлант хугацааны жилүүдэд Экологийн тэнхимээс 2016 онд 3, 2017 онд 7, 2018 онд 8, 2019 онд 10, 2020 онд 5, 2021 онд 5, 2022 онд 7 багш хөтөлбөр мэргэжлээ сурталчлан оролцсон.
- Тухайн хичээлийн жилд мөрдөгдөх шинээр болон шинэчлэгдэн батлагдсан дүрэм, журам, мэргэжлийн хөтөлбөр, багш нарын танилцуулга, оюутны мөрдөх дүрэм журам, сургалтын үйл ажиллагааны хөтөч, оюутанд үзүүлэх үйлчилгээ зэргийг багтаасан дөрвөн бүлэг бүхий эрх зүйн бичиг баримт, Оюутны гарын авлагыг жил бүр хэвлүүлж цахимаар болон ном хэлбэрээр элсэгчдэд түгээдэг.

Онцлог зүйл:

- Элсэлтийг холбогдох хууль дүрэм, журмыг баримтлан зохион байгуулдаг.
- Зөвлөх багш томилон ажиллуулж, шинэ элсэгчдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлдэг.
- ЭЕШ-ын дундаж онооны судалгааг сүүлийн 6 жилээр гаргасан.
- Мөн сүүлийн 6 жилээр тус хөтөлбөрийн элсэгч болон төгсөгчийн судалгааг гаргасан.
- Хөтөлбөрт суралцагчийн тоог сүүлийн 6 жилээр гаргасан.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрт элсэхийг хүсэгчдэд зориулсан мэдээ, мэдээллийн талаар илүү тодорхой болгох.
- Хүсэлт гаргасан болон элссэн суралцагчийн харьцаанд дүн шинжилгээ хийх.
- Цаашид элсэлтийг хэрхэн сайжруулах талаар төлөвлөлттэй байх.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Сүүлийн жилүүдэд элсэлт буурсантай холбоотойгоор элсэлтийн маркетингийг идэвхжүүлэх, өөрчлөх, цахимаар хүсэлт гаргасан болон элссэн суралцагчийн харьцаанд дүн шинжилгээ хийх.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- ХААН КАМПУС хөтөлбөр, “Оюутны хөгжил хөтөлбөр”, “ХААН кампус” хотхон, “Экологийн цэвэр орчин” зэрэг хөтөлбөрүүдтэй.
- “ХААН КАМПУС” хөтөлбөр нь ХААИС-ийн Удирдах зөвлөлийн 2010 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хурлаар батлагдсан ХААИС-ийн стратеги төлөвлөгөө, сургалт, эрдэм шинжилгээ, нийтлэг үйлчилгээг цогцоор нь хамруулсан 20 гаруй хөтөлбөр, төлөвлөгөөг багтаасан бодлогын үндсэн баримт бичиг болно.
- ХААИС нь оюутны мэдлэг, чадвар, хандлагыг хөгжүүлэх зорилгоор Оюутны хөгжил хөтөлбөрийг ХААИС-ийн Удирдах зөвлөлийн 2010 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хурлаар батлагдсан “ХААН КАМПУС” цогц хөтөлбөрт тусган хэрэгжүүлж ирсэн бөгөөд “Оюутны хөгжил хөтөлбөр” нь ХААИС-ийн оюутны хөгжил, төлөвшил, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, цаашдын хөгжлийн загварыг боловсруулан, хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилт, үе шат, арга хэлбэр, механизм, удирдлага, санхүүжилтийг төлөвлөсөн 5 бүлгээс бүрдэх оюутны хөгжлийг тодорхойлсон үндсэн баримт бичиг болно.
- ХААИС-ийн Оюутны хөгжил хөтөлбөрийг 2019 онд шинэчлэн баталсан бөгөөд Удиртгал, Нийтлэг үндэслэл, Эрх зүйн зохицуулалт, Оюутны хөгжил хөтөлбөрийн зорилго, зорилт, үр дүн, Оюутны хөгжил хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө, Хөтөлбөрийн үйл явц, арга хэлбэр, механизм, Хөтөлбөрийн удирдлага, санхүүжилт гэсэн үндсэн хэсгээс бүрдэж байна. (“Оюутны хөгжил хөтөлбөр” бодлогын баримт бичиг, 156-171, Оюутны гарын авлага, 2021)

Онцлог зүйл:

- Оюутанд үзүүлэх үйлчилгээний бодлого зохицуулалт нь олон төрлийн хөтөлбөрийн дагуу хэрэгждэг.
- Тайлант хугацааны туршид ХААИС-ийн СБЗА-аас Оюутны хөгжил хөтөлбөрийн хүрээнд суралцагчдад Хувь хүний хөгжлийн чадамжийн сургалтыг Харилцааны ур чадвар, Эерэг хандлага, Бүтээлч сэтгэлгээ сэдвээр 2021 оны 11 дүгээр сарын 16, 18, 24-нд зохион байгуулж, нийт 530 гаруй оюутан хамрагдсан байна.
- Зөвлөн туслах үйлчилгээг 6 чиглэлээр тогтмол үзүүлдэг.
- Оюутны сэтгэл ханамжийн судалгааг сургалтын байгууллагын үндсэн чиглэлүүдээр авч нэгтгэн дүгнэсэн.

Анхаарах асуудал:

- Судалгаанаас гарсан үр дүнг цаашдын үйл ажиллагаанд хэрхэн тусгаж хөтөлбөрийг сайжруулах талаарх төлөвлөлттэй болох нь зүйтэй.
- ХААИС-ийн хэмжээнд 6 чиглэлээр 24 төрлийн үйлчилгээ үзүүлж байгаа боловч тухайн хөтөлбөрийн оюутнуудыг хамрагдалтын талаарх судалгаа байхгүй.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Зөвлөн туслах үйлчилгээний чиглэлээр ХААИС-ийн хэмжээнд үзүүлж байгаа 24 төрлийн үйлчилгээний талаар тухайн хөтөлбөрийн оюутнуудын хамрагдалтын судалгааг тогтмол хийж, хөтөлбөрийг сайжруулах.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшуулал

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Мэргэжлийн багш жилийн ажлын төлөвлөгөөндөө тухайн хичээлийн жилд удирдах клуб, дугуйлангаа тусган, тэнхимийн эрхлэгчээр батлуулан, үйл ажиллагаагаа явуулдаг.
- Спорт явган аяллын клуб нь жил бүр тогтмол үйл ажиллагаа явуулдаг бөгөөд намрын улиралд Grand tour аялал жуулчлалын улсын тэмцээн, “алтан намар” улсын явган аяллын тэмцээн, хаврын улиралд “туриад” спорт явган аяллын тэмцээнүүдэд 4 хүртэл баг амжилттай оролцуулдаг.
- Захирлын 2016 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А/153 тоот тушаалаар батлагдсан ХААИС-ийн Бакалаврын сургалтын журмын 7 дугаар зүйлд Оюутны урамшууллыг тусгасан бөгөөд ХААИС-д оюутан Захирлын нэрэмжит батламж, Захирлын нэрэмжит тэтгэлэг гэсэн 2 төрлийн тэтгэлгийг хүртэх боломжтой ба “Аялал жуулчлал” хөтөлбөрийн оюутнуудын тэтгэлэгт хамрагдсан судалгааг гаргасан.

Онцлог зүйл:

- Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо сайн. Багш нарын дэмжлэг сайн.
- Урамшуулал, тэтгэлэг, хөнгөлөлтөд сайн хамрагддаг.
- Мэргэжлийн чиглэлийн спорт явган аяллын клубийн үйл ажиллагаа тогтворжиж жилд 3-аас доошгүй тэмцээн уралдаанд оролцож амжилт үзүүлдэг.

Анхаарах асуудал:

- Клуб дугуйлангийн батлагдсан жилийн ажлын төлөвлөгөө, зохион байгуулсан арга хэмжээний тайланг хавсаргах.
- Багш нарын зүгээс оюутны олон нийтийн ажлын оролцоог хэрхэн дэмжиж хамтран ажилладгийг тодорхой тусгах.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоог сургуулийн удирдлагын зүгээс дэмжиж ажиллах, тодорхой санал санаачилгыг хөхиүлэн дэмжих, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажиллах талаар бодлого төлөвлөлтөд тусган ажиллах.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг ХААИС-ийн захирлын 2016 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А/153 тоот тушаалаар батлагдсан ХААИС-ийн Бакалаврын сургалтын журмын 5 дугаар зүйлд зааснаар зохицуулдаг. Үүнд:
 - 5.1 Оюутанд чөлөө олгох
 - 5.2 ХААИС-д шилжин суралцах
 - 5.3 ХААИС-аас шилжүүлэх
 - 5.4 Оюутныг сургуулиас чөлөөлөх зэргээр шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх заалтууд тусгагдсан байна.(Багшийн гарын авлага, ХААИС-ийн Бакалаврын сургалтын журам, 2017 он, хуудас 83-86)
- “ХААИС-ийн бакалаврын сургалтын журам”-ын 5.2.3-т заасан нөхцөлийг хангасан, гадаад, дотоодын магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуулиас оюутан ХААИС-д шилжин суралцах тухай хүсэлтээ бүрэлдэхүүн сургуулийн захиралд гаргах бөгөөд тухайн оюутанд ЭЕШ-ын чиглэл тохирсон, дүйцүүлсэн нийт кредитийн зөрүү 12-оос ихгүй, элссэнээс хойш 1 улирал суралцсан, сурлагын үнэлгээний голч дүн нь 2.0-аас доошгүй байх шалгуур тавигддаг. Шилжилт хөдөлгөөнийг судалгааг тайлант хугацаагаар гаргасан байна.

Онцлог зүйл:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг холбогдох журмын дагуу шийдвэрлэдэг.
- Шилжин ирж буй оюутны кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх талаар оюутанд эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэдэг.
- Тус хөтөлбөрт сүүлийн 5 жилийн хугацаанд суралцсан оюутнуудаас шилжилт хөдөлгөөнийг талаар ямар нэгэн гомдол, санал гараагүй байна.

Анхаарах асуудал:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх боломжтой оюутны судалгаа хийх.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Шилжилт хөдөлгөөнийг судалгаанд дүн шинжилгээ хийж (тухайлбал: өөрийн хүсэлтээр шилжсэн, анги сольсон хөдөлгөөнд илүү анхаарал хандуулах), гарсан үр дүнд чиглэсэн арга хэмжээ авч ажиллах.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

“Аялал жуулчлал” хөтөлбөрөөр төгсөгч нь дараах баримт бичгүүд гарч батлагдсанаар төгсөгчөөр бүртгэгддэг.

1. Төгсөлтийн салбар комиссын тушаал
2. Төгсөлтийн ажил бичих оюутнуудын судалгааны сэдэв, удирдагч, шүүмжлэгчийг тогтоосон тушаал
3. Төгсөлтийн шалгалтад орох тухай тушаал
4. Төгсөгчдөд диплом, энгэрийн тэмдэг олгох тухай тушаал
5. Төгсөлтийн нэгдсэн шалгалтын дүнгийн хуудас

6. Төгсөлтийн нэгдсэн шалгалтын тогтоол
7. Төгсөлтийн үйл ажиллагааны төлөвлөгөө
8. Тойм лекцийн хуваарь
9. Улсын шалгалтын асуултууд
10. Төгсөлтийн шалгалтын тайлан тус тус болно.

Онцлог зүйл:

- Төгсөлтийн үйл ажиллагаа холбогдох журмын дагуу зохион байгуулагддаг.
- Төгсөгчдөөс ажил эрхлэлттэй холбоотой судалгаа авдаг.
- Төгсөгчдийн холбоо байгуулагдсан.

Анхаарах асуудал:

- Аялал жуулчлалын хөтөлбөрөөр бэлтгэгдэн гарч буй мэргэжилтнүүдэд олгох диплом дээр бичигдэх нэршлийг дахин хянах, баталгаажуулах.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- “Аялал жуулчлал” хөтөлбөрөөр төгсөгчдөд батлагдсан хөтөлбөрийн индексийн дагуу зөв нэршилээр дипломын бичилт хийхийг эргэн харж, судлан шийдвэрлэх.

ШАЛГУУР 5-ИЙН ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Захирлын 2017 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 86 тоот тушаалын хоёрдугаар хавсралтаар ХААИС-ийн профессор багш ажиллуулах журмыг баталсан. Энэ журмын дагуу багшийг сонгон шалгаруулдаг.
- Захирлын 2019 оны 6 дугаар сарын 24-ны өдрийн А/199 тоот тушаалын хоёрдугаар хавсралтаар ХААИС-ийн профессор багшийн хөгжил, чадамжийг үнэлэх журмыг баталсан байна. Энэ журмын дагуу багш нарын ажлыг үнэлж дүгнэн зэрэглэл ахиулдаг байна.

Онцлог зүйл:

- Багшийг сонгон шалгаруулж холбогдох журмын дагуу ажиллуулдаг.
- Багш нарын ажлыг үнэлж урамшуулах олон хэлбэр хэрэгждэг.
- Хөтөлбөрт хичээл заадаг багш нар харьцангуй тогтвортой, олон жил ажилласан туршлагатай.

Анхаарах асуудал:

- “Аялал жуулчлал” хөтөлбөрт хичээл заадаг эрдмийн зэрэг, цолтой багшийн тоог нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарах шаардлагатай байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Аялал жуулчлалын мэргэжлийн хичээл ордог докторант багш нарыг эрдмийн зэрэг хамгаалахад дэмжлэг үзүүлж, өндөр ур чадвартай багш нарыг цагаар болон гаднаас урьж ажиллуулах нөхцөлийг хангах.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн тэнхимийн эрхлэгч нарын 2017 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар сайшааж, захиргааны зөвлөлийн 2017 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн хурлаар “Багшийн хөгжил хөтөлбөр” бодлогын баримт бичгийг баталсан байна.
- Багш хөгжлийн төвтэй ба багшлах үйл ажиллагаатай холбоотой төрөл бүрийн сургалт тасралтгүй төлөвлөгөөний дагуу зохион байгуулдаг. ХААИС-ийн багшийн хөгжлийн төв нь сургалтын бодлого зохицуулалтын албанд хамаарах бөгөөд багш нарын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх сургалтын судалгааг хийж, жилийн төлөвлөгөө гарган хэрэгжүүлдэг. Судалгааг багшийн цахим хаягаар хийхдээ google form ашиглан тодорхойлдог. 2020, 2021 болон 2022 онуудад сургалтын төлөвлөгөөний хуваарь гарган ажилласан.
- Багшийн чадамжид суурилсан карьер хөгжлийн төлөвлөгөөг багш нар загварын дагуу жил болгон төлөвлөн ажилладаг.

Онцлог зүйл:

- Багшийн хөгжлийн хөтөлбөр батлагдан хэрэгждэг.
- Багшийн ёс зүйн талаарх 14 асуулга бүхий суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч хэвшсэн.
- Профессор, багшийн хөгжлийн загвар, чадамжийн хүрээг тодорхойлсон.
- Багш нарыг мэдлэг мэргэжлээ дээшлүүлэхэд сургуулийн зүгээс анхаарч ажилладаг.

Анхаарах асуудал:

- Санал асуулга авдаг боловч үр дүнгийн мөрөөр хөтөлбөрийг сайжруулах чиглэлээр цаашид ямар арга хэмжээ авч ажиллах нь тодорхой бус.
- Багшлахуйн ур чадвар, судалгааны ур чадвар, суралцах хэрэгцээг тодорхойлсон судалгаа, судалгааны дагуу хийсэн ажлын баримт, төлөвлөгөө, нотлох баримт тайланд тусгагдаагүй.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Багшлахуйн ур чадвар, судалгааны ур чадвар, суралцах хэрэгцээг тодорхойлсон судалгааны дагуу хийх ажлын төлөвлөгөө, сайжруулах арга замыг оновчтой тодорхойлох.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн багш нар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тасралтгүй хийж, үр дүнг нийтийн хүртээл болгодог талаар тайланд тодорхой тоо, баримтаар тусгасан байна.
- ХААИС-ийн аялал жуулчлал хөтөлбөр нь Erasmus+ MONGWBL төслийг хэрэгжүүлдэг бөгөөд мэргэжлийн багш нарыг 2021 оны 6-р сарын 28-аас 7-р сарын 1, 2022 оны 1-р сарын 26-27, 5-р сарын 16-18, 9-р сарын 19-21-ны өдрүүдэд сургалтад хамруулан, ажлын байранд суурилсан сургалтыг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмжүүдийг өгсөн байна. Сургалтын арга зүйн сургалт, мэргэжлийн сургалтуудад багш нар жилд 2-оос багагүй удаа хамрагдсан байна.

Онцлог зүйл:

- Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажил тогтмолжсон.
- Улсын захиалгат, олон улсын, суурь судалгааны төсөл боловсруулан гүйцэтгэдэг.
- Оюуны өмч, зохиогчийн эрх авсан бүтээлийн тоо 2016 онд 6, 2017 онд 8, 2019 онд 8, 2021 онд 8 болж 33 хувиар өссөн.
- Эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн тоо 2016 онд 64, 2017 онд 58, 2018 онд 64, 2019 онд 56, 2020 онд 40, 2021 онд 62 болж өссөн.

Анхаарах асуудал:

- Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулсан төсвийн гүйцэтгэлийн судалгаа байхгүй.
- Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг сургууль, удирдлагын зүгээс хэрхэн дэмждэг талаар тайланд тусгагдаагүй.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулдаг төсвийн талаар тодорхой болгож, цаашид нэмэгдүүлэх.
- Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн хөтөлбөр хэрэгжүүлэхэд хэрхэн нөлөөтэй байгаа талаар судалж тодорхойлох.

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Багш нар календарийн он бүрээр ажлын төлөвлөгөөгөө гаргаж бүрэлдэхүүн сургуулийн захирлаар баталгаажуулдаг. Оны төгсгөлд өөрийн үнэлгээний тайланг хэлэлцүүлэхдээ төлөвлөгөөний гүйцэтгэлийн хувийг тайлагнадаг байна.
- Багш өөрийн үнэлгээгээ хийн хамт олноор хэлэлцүүлдэг ба хөндлөнгийн үнэлгээг багш нар, удирдлагууд хийдэг байна.
- ХААИС нь бүх багш нарын ажил, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний үр дүн үнэлж албан тушаалын зэрэглэлийг ахин тогтоох үйл ажиллагааг хамгийн сүүлд 2014 онд албан ёсоор зохион байгуулсан бөгөөд энэ үед аялал жуулчлалын мэргэжлийн багш

нараас доктор Л.Баясгалан дэд профессороос профессор, Б.Баасаннамжий, М.Уянга, Н.Сарангарав нар нь багшаас ахлах багшийн зэрэглэлд албан тушаал дэвшсэн. Үүнээс хойш мэргэжлийн багш нарын хувьд албан тушаалын зэрэглэл нэмэгдээгүй, мөн буураагүй байна.

- Захирлын 2017 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 86 тоот тушаалын II хавсралт Профессор багшийн хөгжил, чадамжийн түвшнийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн дагуу ХААИС нь жил бүр багш нарын баяраар оны шилдгүүдийг шалгаруулдаг. Тухай бүрд нь удирдамжийг шинэчлэн баталгаажуулдаг. Шилдгүүдийг
 - Оны шилдэг залуу багш
 - Оны шилдэг судлаач
 - Оны шилдэг сурган хүмүүжүүлэгч
 - Оны шилдэг тэнхим гэсэн 4 үзүүлэлтэд шалгаруулдаг.

Онцлог зүйл:

- Багшийн өөрийн үнэлгээг хамт олноор хэлэлцдэг, хөндлөнгийн үнэлгээг сургуулийн удирдлагаас хийдэг.
- Багш нарыг аттестатчилж, зэрэглэлийг ахиулдаг тогтолцоотой.

Анхаарах асуудал:

- Багш нарын өөрийн үнэлгээнд дүн шинжилгээ хийж, цаашид сайжруулах бодлого, төлөвлөлт байдаг эсэх нь тодорхойгүй байна.
- Багш нарын ажилд хөндлөнгийн үнэлгээ хийсэн дүн шинжилгээ байхгүй.
- Багшийн үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний тайлан тусгагдаагүй.

Үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Зөвлөмж:

- ХААИС нь 2014 оноос хойш бүх багш нарын ажил, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний үр дүнг үнэлж албан тушаалын зэрэглэлийг ахин тогтоох үйл ажиллагааг албан ёсоор зохион байгуулснаас хойш бараг 10 жил өнгөрч байгааг анхаарч, шинээр зохион байгуулах.

Шаардлага:

- Багш нарын өөрийн үнэлгээнд дүн шинжилгээ хийж, цаашид сайжруулах бодлого, төлөвлөгөө гаргаж ажиллах.
- Багш нарын ажил, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний үр дүнг үнэлж, албан тушаалын зэрэглэлийг ахин тогтоох үйл ажиллагааг шинээр зохион байгуулах.

ШАЛГУУР 6-ИЙН ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС нь 2014 онд бүтцийн өөрчлөлтөөр Бодлогын мониторинг, үнэлгээ хөгжлийн албыг татан буулгаж, захиргааны албаны бүтцэд хяналт шинжилгээний мэргэжилтэн, 2015 онд аудит, 2016 онд хяналт шинжилгээ, чанар хариуцсан мэргэжилтэнтэй болсноор дотоод чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлж байгаад 2018 оноос Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас Азийн хөгжлийн банктэй хамтран хэрэгжүүлж буй “Дээд боловсролын шинэчлэл” төслийн хүрээнд Хөдөө аж ахуйн их сургууль нь сургалт, эрдэм шинжилгээ болон бусад холбогдох чиглэлийн үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулах зорилгоор Чанарын удирдлага, зохицуулалтын албыг (ХААИС-ийн захирлын 2018 оны Б/283 тоот тушаал) байгуулан ажиллаж байна.
- ХААИС нь хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтыг хангах удирдлага зохион байгуулалтын 3 түвшинтэй буюу хөтөлбөрийн ерөнхий хороо, дэд хороо, мэргэжлийн хөтөлбөрийн хороо гэсэн бүтэцтэй.
- Аялал жуулчлал мэргэжлийн хөтөлбөрийн хороо анх 2015 оны 01 дүгээр сарын 19 өдөр байгуулагдан 2016, 2017, 2018, 2019, 2021 онуудад шинэчлэгдэн, одоо 12 гишүүний бүрэлдэхүүнтэй ажилладаг.

Онцлог зүйл:

- ХААИС-ийн “Аялал жуулчлал” сургалтын хөтөлбөр нь 2011 оны 06 сарын 23-ны өдөр дотоодын магадлан итгэмжлэл хийлгүүлэн БМИҮЗ-ийн 75 тоот гэрчилгээг гардан авсан нь Монгол улсын хэмжээнд байгалийн аялал жуулчлал хөтөлбөрийн анхны магадлан итгэмжлэл болсон байдаг. Анхны магадлан итгэмжлэлийн үед мэргэжлийн зөвлөлөөс 4 хэсэг бүхий зөвлөмж ирүүлснийг 2011 онд засварлан сургалтын төлөвлөгөөний харьцааг зөвлөмжийг дагуу шинэчилж ХААИС-иар батлуулан хүлээлгэн өгснөөр Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн даргын 2011 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 45 тоот тогтоолоор магадлан итгэмжилсэн шийдвэр гарч байсан.
- Аялал жуулчлал мэргэжлийн 2017-2027 оны стратеги төлөвлөгөөг 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдөр боловсруулсан. Энэхүү төлөвлөгөө нь 2 үе шаттай бөгөөд 1-р үе шат нь 2017-2022 он, 2-р үе шат нь 2022-2027 оноор төлөвлөгдсөн. Үндсэн 6 зорилттой байхаар төлөвлөгдсөн. Эхний үе шатын биелэлтийг 2023 онд дүгнэж үзээд давуу, сул талаа тодорхойлохоор ажиллаж байна.
- Аялал жуулчлал хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүнд сонирхогч талуудын төлөөлөл болох төгсөгч 2, ажил олгогч 2, оюутан 1 ажиллаж санал асуулга, хурал, хэлэлцүүлэгт идэвхтэй оролцон хөтөлбөрийн хэрэгжилт, шинэчлэлт, өөрчлөлтөд санал бодлоо тусгадаг.

Анхаарах асуудал:

- ХААИС нь хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг хангах нэгж, алба байгаа хэдий ч тэдгээрийн явуулж байгаа үйл ажиллагаа, бодлогууд нь хоорондоо уялддаггүй, нарийн мэргэжлийн төлөөлөл байхгүй. Тухайлбал, сургалтын алба болон ЧУА нь 2021 онд оюутан, багш нараас сэтгэл ханамжийн судалгааг давхцуулан явуулсан нь ажлын ялгаа, уялдаа холбоог хангаагүй байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- ХААИС-ийн Чанарын удирдлагын албаны чиг үүргийг нарийвчлан тогтоох замаар Сургалтын бодлого зохицуулалтын албаны үндсэн чиг үүргээс зааглаж ажлын давхардлыг арилгах.

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- 2017-2022 нийт 103 оюутан төгссөнөөс судалгаанд 100 хувь хамрагдсан. Судалгаанд оролцогсдын ажил эрхлэлтийн хувийг авч үзвэл мэргэжлээрээ 15.5% (16 төгсөгч), мэргэжлийн бус 46.6% (48), хувиараа ажил эрхлэгч 9.7% (10) үргэлжлүүлэн суралцаж байгаа 5.8% (6), ажилгүй 21.3% (22) тус тус эзэлж байна. Нийт төгсөгчдийн ажил эрхлэлт 71.8%-тай байна.
- Хөдөө аж ахуйн их сургуулийн оюутнууд улирлын төгсгөл бүрт өөрийн дүнг харахын тулд оюутны программ руу орж хичээл заасан багшийн талаар болон суралцах орчны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээг өгдөг. Энэхүү судалгааг 2018-2022 онуудад “Аялал жуулчлал” хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудаас авахад оюутнуудын сэтгэл ханамжийн түвшин дунджаар 4.52 оноо буюу сайн байна.
- 2020 онд ХААИС-ийн сургалтын бодлого зохицуулалтын алба нь аялал жуулчлал хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийж дүгнэлт гаргасан. 86.18 хувийн үнэлгээ авч цаашид сайжруулах зөвлөмжийг авсан байна.

Онцлог зүйл:

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын ажлын төлөвлөгөөний дагуу жил бүр төгсөгчдөөс сэтгэл ханамжийн судалгаа авч хэвшсэн.
- Хөтөлбөрийн чанарыг сайжруулах арга хэмжээний стратеги төлөвлөгөөтэй ажиллаж байна.
- Оюутны сэтгэл ханамжийн үнэлгээг 2018 онд нийт 88 оюутнуудаас авахад мэргэжилдээ 66,6 хувь нь сэтгэл ханамжтай, 32,18 хувь нь сэтгэл ханамж дунд, 1,15 хувь нь сэтгэл ханамж бага зэрэг байдаг гэсэн үр дүн гарсан байна.

Анхаарах асуудал:

- Ажил олгогчдын дийлэнх нь буюу 54 хувь нь төгсөгчдийг ажиллуулж байгаадаа сэтгэл хангалуун, 42 хувь сайн гэсэн боловч 4 хувь нь сэтгэл дундуур байгаа нь цаашид төгсөгчдийн мэдлэг ур чадварт анхаарах, сургалтаа сайжруулахад шаардлагатай байна.
- Төгсөгчдөөс авсан судалгааны үр дүн болон шинжээчдийн оролцогч талуудтай хийсэн ярилцлагын явцад төгсөгчдийн хамгийн сул чадвараар үнэлсэн гадаад хэлний мэдлэгийг сайжруулах талаар яг ямар арга хэмжээ авсан буюу авахаар төлөвлөж байгаа нь тодорхойгүй байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Төгсөгчдөд чадавхжуулах сургалт явуулж эхлэх, ажил олгогчдоос авсан санал хүсэлтийн дүн шинжилгээний үр дүнг сургалтын процесс арга зүйг сайжруулах, төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг сайжруулах, төгсөгчдийг мөшгөх судалгааг оновчтой ашиглах менежментийг Хөтөлбөрийн хэмжээнд хэрэгжүүлэх шаардлагатай.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Аялал жуулчлал хөтөлбөрөөр Өвөр Монголын өөртөө засах орноос нэг оюутан суралцаж 2020 онд төгссөн бөгөөд үргэлжлүүлэн аялал жуулчлалын магистрын ангид амжилттай суралцаж 2022 онд төгссөн байна.
- ОХУ-ын Новосибирскийн ХААИС, Буриадын ХААИС, Эрхүүгийн ХААИС, Солонгосын Чонбүкийн ҮИС, Шиньяаны ХААИС-д аялал жуулчлал хөтөлбөрөөр суралцах боломжтой.
- Их сургуулийн хэмжээнд хөтөлбөр сургалт, судалгаа, сургалтын болон үйлдвэрлэлийн дадлага хийх, харилцан туршлага солилцох чиглэлээр гадаад дотоодын байгууллагатай хамтрах үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2021 оноос Европын холбооны санхүүжилттэй Erasmus + MONGWBL “Ажлын байранд түшиглэсэн сургалтын нэвтрүүлэх замаар төгсөгчдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх нь” төсөлд хамтрагчаар оролцож үйлдвэрлэлийн дадлагын үр дүнг сайжруулахаар ажиллаж байна.

Онцлог зүйл:

- Тус сургалтын хөтөлбөр нь 2011 оны 06 сарын 23-ны өдөр дотоодын магадлан итгэмжлэл хийлгүүлэн БМИҮЗ-ийн 75 тоот гэрчилгээг гардан авсан нь Монгол улсын хэмжээнд байгалийн аялал жуулчлал хөтөлбөрийн анхны магадлан итгэмжлэл болсон байна.
- 2023 онд Дотоодын магадлан итгэмжлэл хийлгэсний дараа Олон улсын хэмжээнд магадлан итгэмжлэлд хамрагдахаар төлөвлөн ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Тэнхим, сургуулийн хэмжээнд ЧУТ-ны болон ISO 21001:2018 боловсролын чанарын удирдлагын стандартын сургалт хийгдээгүй.
- Хөндлөнгийн баталгаажуулалтыг цаашид бий болгож, сайжруулах бодлого төлөвлөлт тусгагдаагүй.

Үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Зөвлөмж:

- Сургалтын бодлого зохицуулалтын алба, ЧУА болон Хөтөлбөрийн Хорооны гишүүд, багш нарыг Чанарын удирдлагын сургалтанд хамруулж, улмаар олон улсын холбогдох магадлан итгэмжлэлд хамрагдах бэлтгэл ажлыг хангаж ажиллах нь зүйтэй.

Шаардлага:

- ISO 9001:2015 чанарын удирдлагын тогтолцоо, ISO 21001:2018 боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо стандартуудыг нэвтрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах шаардлагатай.

ШАЛГУУР 7-ИЙН ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: БҮРЭН ХАНГАСАН

ДҮГНЭЛТ

ХААИС-ийн АЭС-ийн “Аялал жуулчлал” бакалаврын хөтөлбөр нь хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн 4 дэд шалгуурыг хэсэгчлэн хангасан, бусад дэд шалгууруудыг бүрэн хангасан тул бүхэлдээ **7 шалгуурыг бүрэн хангасан** хэмээн шинжээчийн баг дүгнэлээ.

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаа-гүй (0)	Үндэслэл, шалтгаан /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал бичнэ/
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3			
2	Сургалтын үйл ажиллагаа	3			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2	1 /3.2/		-Сургалтын хэрэглэгдэхүүний, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгааг хийж, сайжруулах. -Цахим сургалтын хэрэглэгдэхүүнийг хөгжүүлж, сургалтад бүрэн ашиглах
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	4	1 /4.3/		-Хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх сургуулийн төсөв, багшийн хөгжлийн төсөв, түүний зарцуулалтын илүү тодорхой болгож, хүртээмжийг нэмэгдүүлэх. -Нэг суралцагчийн өртгийн тооцоог ерөнхий дундажаар бус, боловсролын үйлдэл, үйл ажиллагаа, хөтөлбөрийн онцлог болох чадамжид суурилан тооцох. -Төр хувийн хэвшлийн дэмжлэг, санхүүжилт нь санхүү, түүний зарцуулалтын тайланд, сургуулийн түвшинд, хөтөлбөрийн түвшинд санхүүгийн мэдээ баримтанд тусгадаг байх. -Ном сурах бичиг үндсэн хөрөнгийн бүртгэл мэдээлэл санхүүгийн бүртгэлд бүрэн тусгаж баримтжуулдаг байх.
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5			

6	Багшийн үйл ажиллагаа	3	1 /6.4/	<p>-Багш нарын өөрийн үнэлгээнд дүн шинжилгээ хийж, цаашид сайжруулах бодлого, төлөвлөлт байдаг эсэх нь тодорхойгүй байна.</p> <p>-Багш нарын ажилд хөндлөнгийн үнэлгээ хийж, ахиц дэвшлийг үнэлэх.</p>
7	Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	2	1 /7.3/	<p>-Тэнхим, сургуулийн хэмжээнд ЧУТ-ны болон ISO 21001:2018 боловсролын чанарын удирдлагын стандартын сургалтууд зохион байгуулах.</p> <p>-Хөндлөнгийн баталгаажуулалтыг цаашид бий болгож, сайжруулах бодлого төлөвлөж хэрэгжүүлэх.</p>
Дүгнэлт		Бүрэн хангасан		

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	ХААИС-ийн Агроэкологийн сургууль
Хөтөлбөрийн нэр	Аялал жуулчлал
Хөтөлбөрийн индекс	101501 бакалавр
ЗӨВЛӨМЖ	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> ➤ “Аялал жуулчлал” хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд одоо хэрэгжиж байгаа Европын холбооны Erasmus+ MONGWBL төслийн туршилтын үр дүнгээр сайжруулалт хийж болох ч цаашид нийт кредит цагийг өөрчлөхгүйгээр харин дадлагын ажлын чанар, сургалтын арга зүйг илүү сайжруулах замаар хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангаж ажиллах.
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> ➤ Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг сургалтын шинэлэг арга зүйгээр боловсруулж, цогц чадамжид суурилсан сургалтын арга зүйг илүү тодорхой болгох. ➤ Хичээл тус бүрээр, цаашид хөтөлбөрийн үнэлгээг хийх.
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	<ul style="list-style-type: none"> ➤ Сургалтын хэрэглэгдэхүүний, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгааг чанаржуулах, судалгааны үе дүнгээр сайжруулалт хийдэг байх, сайжруулалт хийснээ дүгнэн оруулдаг тасралтгүй циклийг бий болгох. ➤ Цахим сургалтын хэрэглэгдэхүүнийг хөгжүүлж, сургалтад бүрэн ашиглах.
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> ➤ Боловсрол олгох үйл явц, боловсролын түвшний ялгаатай байдлаар сургалтын төлбөр, нэг кредитийн үнэлгээг эзэмшүүлж буй мэдлэг чадвар дадал буюу чадамжид тулгуурлан тогтоох. ➤ Сургалтын болон сургалтыг дэмжих программуудаа нэгтгэх, ашиглалтыг сайжруулан мэдээллийг тухай бүр шинэчлэх.
Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> ➤ Сүүлийн жилүүдэд элсэлт буурсантай холбоотойгоор элсэлтийн маркетингийг идэвхжүүлэх, өөрчлөх, цахимаар хүсэлт гаргасан болон элссэн суралцагчийн харьцаанд дүн шинжилгээ хийх. ➤ Аялал жуулчлал” хөтөлбөрөөр төгсөгчдөд батлагдсан хөтөлбөрийн индексийн дагуу зөв нэршилээр дипломын бичилт хийхийг эргэн харж, судлан шийдвэрлэх.
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> ➤ Аялал жуулчлалын мэргэжлийн хичээл ордог докторант багш нарыг эрдмийн зэрэг хамгаалахад дэмжлэг үзүүлж, өндөр ур чадвартай багш нарыг цагаар болон гаднаас урьж ажиллуулах нөхцөлийг хангах. ➤ Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулдаг төсвийн талаар тодорхой болгож, цаашид нэмэгдүүлэх.
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	<ul style="list-style-type: none"> ➤ ХААИС-ийн Чанарын удирдлагын албаны чиг үүргийг нарийвчлан тогтоох замаар Сургалтын бодлого зохицуулалтын албаны үндсэн чиг үүргээс зааглаж, ажлын давхардлыг арилгах. ➤ Сургалтын бодлого зохицуулалтын алба, ЧУА болон Хөтөлбөрийн хорооны гишүүд, багш нарыг чанарын удирдлагын сургалтад хамруулж, улмаар олон улсын холбогдох магадлан итгэмжлэлд хамрагдах бэлтгэл ажлыг хангаж ажиллах.

Шалгуур	➤ Шаардлага
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	<ul style="list-style-type: none"> ➤ Сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмж, ашиглалтын талаар давтамжтай нарийвчилсан судалгааг багш, оюутнаас тасралтгүй авч, судалгааны үр дүнгээр сайжруулалт хийх ➤ Е-контент түвшинд боловсруулсан сургалтын материалыг сайжруулах.
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> ➤ Аялал жуулчлалын хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэсэн шинэчлэлт, өөрчлөлтөнд зориулсан төсөв, түүний гүйцэтгэл, дүн шинжилгээг тогтмол хийдэг байх. ➤ Хөтөлбөрийн санхүүжилт, орлого, зардлын тооцоог ил тод байлгах. Тухайлбал, сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүнгийн судалгааг гаргадаг байх. ➤ Хөтөлбөрийн санхүүжилтийн олон эх үүсвэртэй болох, мөн хөтөлбөрт олгож буй төр хувийн хэвшлийн дэмжлэг, санхүүжилтийн зарцуулалтыг тогтмол тайлагнадаг байх. ➤ Хөтөлбөрөөр суралцагчдын өртөг, үр ашгийн тооцоог тогтмол хийдэг байх. ➤ Багшийн хөгжлийн төсөв, түүний зарцуулалтын тайлан мэдээ, үр дүнг тайлагнадаг байх.
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> ➤ Багш нарын өөрийн үнэлгээнд дүн шинжилгээ хийж, цаашид сайжруулах бодлого, төлөвлөгөө гаргаж ажиллах. ➤ Багш нарын ажил, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний үр дүнг үнэлж, албан тушаалын зэрэглэлийг ахин тогтоох үйл ажиллагааг шинээр зохион байгуулах.
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	<ul style="list-style-type: none"> ➤ Сургуулийн хэмжээнд ISO 9001:2015 чанарын удирдлагын тогтолцоо, ISO 21001:2018 боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо стандартуудыг нэвтрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах.

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Хөдөө аж ахуйн их сургуулийн Агроэкологийн сургуулийн “Аялал жуулчлал” 101501 хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна. Шинжээчийн багийн дүгнэлтийг Үйлчилгээний чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг/Д.ГАНСҮХ /

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Ч.МӨНХЖАРГАЛ/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../ Ц.ПҮРЭВТУЯА/

IV.Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нартай хийх уулзалт

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилла сан жил	Заадаг хичээл
1	А.Амарсайхан	багш	Магистр	20	Мэргэжлийн англи хэл
2	Ч.Хулан	Дэд проф	Доктор, Ph.D	23	Монгол хэл бичиг, найруулга зүй
3	Б.Лхагвадорж	ахлах багш	Доктор, Ph.D	15	Монголын түүх, соёл, ёс заншил
4	Б.Биндэръяа	Дэд проф	Доктор, Ph.D	25	Ургамал, амьтны ангилал зүй, тархалт
5	Г. Эрдэмбилэг	Дэд проф	Доктор, Ph.D	20	Ургамал, амьтны ангилал зүй, тархалт
6	П.Ариунсүрэн	Дэд проф	Доктор, Ph.D	29	Тусгай сонирхлын аялал жуулчлал
7	Л.Загдсүрэн	Ахлах багш	Магистр	16	Биеийн тамир, эрүүл ахуй
8	Д.Эрдэнэбаатар	Ахлах багш	Доктор, Ph.D	26	Гамшгаас хамгаалах менежмент
9	Н.Цэгмид	Ахлах багш	Доктор, Ph.D	21	Экологи байгаль хамгаалал, Дэлхий судлал
10	Б.Баасаннамжий	Ахлах багш	Магистр	25	Аялал жуулчлалын үндэс, Зочлох үйлчилгээний менежмент, Байгалийн аялал жуулчлалын маркетинг, Хөдөөгийн аялал жуулчлал, Харилцаа, инноваци
11	М.Уянга	Ахлах багш	Магистр	27	Аялал жуулчлалын бизнесийн харилцаа, Аялал жуулчлалын бизнесийн эрх зүй, Аялал жуулчлалын хүний нөөц, Жуулчны аюулгүй байдал, даатгал, Байгалийн аялал жуулчлалын менежмент, Аялал жуулчлалын эдийн засаг
12	Х.Ганчимэг	багш	Магистр	24	Монгол орны байгалийн газарзүй
13	Н.Сарангарав	Ахлах багш	Магистр	18	Байгалийн аялал жуулчлал, Олон улсын аялал жуулчлал, Хөтөч тайлбарлагчийн арга техник, Рекреацийн газарзүй, Тусгай сонирхлын аялал жуулчлал, Тогтвортой аялал жуулчлал
14	Ч.Ууганбаяр	Ахлах багш	Магистр	20	Тусгай сонирхлын аялал жуулчлал

15	Б.Сэр-Од	багш	Магистр	19	Газарзүйн мэдээллийн системийн хэрэглээ
16	Д.Баяржаргал	Ахлах багш	Доктор, Ph.D	3	Хятад хэл

II. Оюутан, суралцагчидтай хийх уулзалт

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал	Утас
1	Б.Долгорцэнд	1	Орон нутгийн, дотуур байранд амьдардаг	94158247
2	Н.Анхмаа	1	Орон нутгийн, дотуур байранд амьдардаг	94216905
3	Ч.Нармандах	2	Хөгжлийн бэрхшээлтэй	95590342
4	О.Баяржаргал	2	Орон нутгийн	80570922
5	Ө.Хосбаяр	2	Оюутны зөвлөлийн гишүүн	99923083
6	Б.Айдана	2	Ангийн дарга	85553650
7	Ө.Энгүй-Эрдэнэ	2	Улаанбаатар	99150141
8	Б.Пүрэвбат	2	Шилжиж ирсэн	80763833
9	Д.Сансар	3	Орон нутгийн	99039459
10	О.Индра	3	Улаанбаатар	99774825
11	Б.Чулуунбаатар	3	Орон нутгийн	95626656
12	Б.Мөнхцэцэг	3	Ангийн дарга	95512377
13	М.Ганбилэг	3	Улаанбаатар	95292181
14	Д.Болортунгалаг	3	Улаанбаатар	86117887
15	Б.Хосбаяр	3	Улаанбаатар	99123095
16	Д.Баяржавхлан	3	Шилжиж ирсэн	96279344
17	Т.Түмэндорж	4	Оюутны зөвлөлийн дэд дарга	86670524
18	Б.Оргилболд	4	Орон нутгийн, дотуур байранд амьдардаг	80906964
19	Б.Аймэлдир	4	Орон нутгийн	
20	М.Бердыхажы	4	Орон нутгийн	88253297
21	Б.Эрхэмбаяр	4	Орон нутгийн	94957695
22	Ө.Мөнхбат	4	Орон нутгийн	88535006

III. Ажил олгогчидтой хийх уулзалт

№	Овог нэрс	Ажлын газар	Албан тушаал	Утас
1	Ц.Төгсбуян	Эрдэнэт цогцолбор сургууль	ЭШХА хариуцсан орлогч дарга	99992846
2	Батцэцэг	МУБИС-Биеийн тамирын сургууль	Хөтөлбөрийн албаны дарга	91913696
3	Алтанцэцэг	Булган аймгийн ЗДТГ	Орчны бохирдол хариуцсан мэргэжилтэн	99718018
4	А.Наранцэцэг	Дорнод аймаг, Хэрлэн сумын ЗДТГ	ЗДТГ-ын дарга	88881901
5	Г.Ганзориг	Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын архив	Тасгийн дарга	99012499
6	С.Амгаабазар	ХААИС-ийн бие бялдар хүмүүжлийн тэнхим	Тэнхимийн эрхлэгч	99191686

7	Г.Хишигжаргал	Таванбогд ХХК	Хүний нөөц хариуцсан захирал	99999378
8	Б.Сарантуяа	Говьсүмбэр аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар	Умард говийн сав газрын захиргааны ахлах мэргэжилтэн	86051533
9	Д.Нармандах	Маунт гуард ХХК	Хүний нөөцийн менежер	90113075
10	А.Чанцалдулам	Хөнгөн Бетон ХК	Хүний нөөцийн албаны дарга	
11	Ц.Минжинхүү	Дулааны II ЦС	Гүйцэтгэх захирал	93311111
12	Лхагва	Juulchin ХХК	Хүний нөөцийн менежер	99094374
13	Л.Баасанхүү	KingseaE&C consulting Group Go Ltd.	Захирал	98111987, 88050224
14	Урангоо	"English school of Mongolia" ахлах сургууль	Хүний нөөцийн менежер	99613537
15	М.Болормаа	Хар зүрхний хөх нуур жуулчны бааз	Захирал	99171675
16	Б.Золхүү	Сүхбаатар аймгийн соёл урлагийн хэлтэс	Хэлтсийн дарга	99162248
17	Т.Ханддулам	New juulchin ХХК	менежер	99034578
18	С.Солонгоо	Дорнод аймгийн ЗДТГ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс хариуцсан мэргэжилтэн	
19	Г.Эрдэнэбадрах	Сейф Трэк ХХК	Ерөнхий менежер	99021223
20	Н.Бишрэм-Өлзийт	REMAX ҮХХ-ийн зууч	Борлуулалт хариуцсан захирал	80104677
21	Э.Дөлгөөн	Билгүүн бар констракшн	Борлуулалт хариуцсан захирал	99922895
22	Г.Энхзаяа	Car Doctor ХХК кафе	Захирал	88293634
23	Kelvin Kaukinen	Barloworld Equipment ХХК	Гүйцэтгэх захирал	80248080
24	Г.Оюун-Эрдэнэ	Монголын нууц товчоо	Захирал	99993200
25	Мөнхсайхан	Баянзагийн дурсгалт газрын мэдээллийн төв	Дарга	89441212
26	Эрдэнэханд	Мөнх Тэргүүн тур ХХК	Захирал	99162538

IV. Төгсөгчидтэй хийх уулзалт

№	Овог нэрс	Төгссөн он	Ажлын газар	Албан тушаал
1	Б.Баярмаа	2022	Zen ресторан	зөөгч
2	О.Ариунзаяа	2022	Сайн электроникс / Баянзагийн дурсгалт газрын мэдээллийн төв	зээлийн эрсдэл судлаач/ажилтан

3	У.Ичинхорлоо	2022	"Монголын нууц товчоо" жуулчны бааз	Ресепшин
4	У.Тэмүүлэн	2022	Мөнх тэргүүн тур ХХК	Хөтөч
5	Э.Батмагнай	2022	"Говийн наран" жуулчны бааз	Менежер
6	Б.Бархас	2021	Япон улсын Synergy компани	Дагалдан ажилтан
7	Д.Хонгорзул	2021	Бодь даатгал	Салбар хариуцсан менежер
8	Э.Сугармаа	2021	"Remax" үл хөдлөх хөрөнгийн зуучлалын компани	Зуучлагч
9	Ш.Жавзандулам	2021	Хувиараа бизнес эрхэлдэг	Гадаад худалдаа
10	Б.Ундармаа	2021	"Аянчин аутфитерс"	Худалдаан зөвлөх
11	Б.Дуламсүрэн	2020	MGG group	Худалдааны төлөөлөгч
12	Э.Мөнхчимэг	2020	Дорнод аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс	Байгаль орчин, аялал жуулчлалын мэргэжилтэн
13	О.Болор	2020	"Монголын нууц товчоо" жуулчны бааз	Менежер
14	Т.Ариунзул	2020	Мобиком корпорац	Авлага хариуцсан менежер
15	Г.Далайцэрэн	2019	Пийк Ойл ХХК-ийн Овоот уурхайн SGS camp	Кэмп менежер
16	Э.Энхтогтох	2019	Морин өртөө групп	Аяллын менежер
17	Р.Цэндмаа	2019	Хувиараа бизнес эрхэлдэг	Валют арилжаа
18	Б.Энхтүвшин	2019	"Аялал жуулчлал менежмент, тээвэр, шуудан" ХХК	Аяллын хөтөч
19	С.Айжанар	2018	"Хар зүрхний хөх нуур" жуулчны бааз	Менежер
20	Х.Зангибай	2018	Жасмура ХХК	Менежер

V.Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬ
АГРОЭКОЛОГИЙН СУРГУУЛЬ

17024 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
22 дугаар хороо, Зайсан 5, Утас: 7510 7777 243
И-мэйл: agroecology@mul.s.edu.mn
Вэб сайт: www.mul.s.edu.mn

2023.03.07 № 01/84
танай _____ -ны № _____ -т

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

“Аялал жуулчлал” бакалаврын хөтөлбөрийн шинжээчийн баг ажиллаж 7 шалгуур бүрээр шинжилгээ хийж 13 ерөнхий зөвлөмж 10 шаардлага бүхий тайлан ирүүлснийг хүлээн авч танилцлаа. Шинжээчийн тайланг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд өгсөн зөвлөмж, шаардлагын дагуу цаашид хөтөлбөрөө сайжруулан ажиллах болно.

Тус хөтөлбөрийг магадлан итгэмжлэх үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу үргэлжлүүлэн явуулж өгнө үү.

ЗАХИРАЛ



А.БУЯНБААТАР

023705084